



МЭДРЭМЖТЭЙ  
МЭДЭЭЛЬЕ

# СОНГУУЛИЙГ МЭДРЭМЖТЭЙ СУРВАЛЖЛАХ НЬ

Редакцуудад зориулсан удирдамж



Улаанбаатар хот, 2023 он

СОНГУУЛИЙГ МЭДРЭМЖТЭЙ СУРВАЛЖЛАХ НЬ  
Редакцуудад зориулсан удирдамж  
Улаанбаатар хот, 2023 он

Энэхүү удирдамжийг Хэвлэл мэдээллийн зөвлөл боловсруулж НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн санхүүжилтээр хэвлэв.

Бүтээлд илэрхийлсэн үзэл санаа, дүгнэлт нь зохиогчдынх бөгөөд төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын Олон Улсын байгууллага (КОЙКА) болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Удирдамжийг боловсруулсан Д.Мөнхчимэг, Б.Нямзул  
Хянан тохиолдуулсан Э.Эрдэнэчимэг  
Эх бэлтгэл, график дизайныг Анлимитэд Медиа группийн хамт олон гаргав.

# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
Яагаад сонгуулийг жендэрийн мэдрэмжтэй мэдээлж, сурвалжлах хэрэгтэй вэ?	6
Сонгуулийн тогтолцооны талаар сэтгүүлч, редакцын мэдвэл зохих агуулга	8
<b>СОНГУУЛИЙН ӨМНӨ</b>	14
Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг сурвалжлахаасаа өмнө юуг анхаарах вэ?	15
Редакц юу хийх ёстой вэ?	16
Нөөц хэрэглэгдэхүүн. Эх сурвалжийн мэдээллийн сан	17
Сэтгүүлч юу хийх ёстой вэ?	18
<b>СОНГУУЛИЙН ҮЕЭР</b>	20
Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвээр бүтээл хийх нь	21
<b>БЭЛТГЭЛ ШАТ</b>	22
Редакцын хэрэгжүүлэх 7 алхам	22
Сэтгүүлчид өгөх зөвлөгөө	23
Нөөц хэрэглэгдэхүүн: Гэрэл зургийн нээлттэй сан	23
Нөөц хэрэглэгдэхүүн: Өгөгдлийн дүрслэлийн сан	23
<b>БҮТЭЭЛ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ШАТ</b>	24
Эх сурвалжийн гурван түвшин	24
Эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах алхмууд	25
Эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтоос зайлсхийх	26
<b>ЗУРГААН АЛХАМ</b>	26
Эмэгтэй нэр дэвшигчийн зураг, дүрсийг авахдаа гаргадаг түгээмэл алдаанаас зайлсхийх нь	28
Хүйс үл хамааран нэр дэвшигчдийг хэрхэн мэдрэмжтэй гаргах вэ?	30
Эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтыг эвдэхэд туслах арга замууд	32
<b>БҮТЭЭЛ БЭЛЭН БОЛСНЫ ДАРАА</b>	33
Редакц, сэтгүүлч юу хийх ёстой вэ?	33
Жендэрийн сэдвээр бичих сэтгүүлч, редакторын хяналтын хуудас	33
<b>СОНГУУЛИЙН ДАРАА</b>	34
Сонгуулийн үр дүнг жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх нь	35
Үл тасрах тойрог:	35
Сонгогчдын боловсрол, жендэрийн мэдрэмжийг сайжруулах нь	38
<b>ХАВСРАЛТ</b>	
<b>Хавсралт 1.</b> 2024 оны УИХ-ын сонгуулийн үеэр сэтгүүлчдийн мэдвэл зохих чухал үйл явдлын хураангуй цаглавар	41
<b>Хавсралт 2.</b> Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг сурвалжлах нь	42
<b>Хавсралт 3.</b> Эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрх	44
<b>Хавсралт 4.</b> Хууль эрх зүйн шинэчлэл	45
<b>Хавсралт 5.</b> Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөллийг хангах улс төрийн намын амлалт	47
<b>Хавсралт 6.</b> Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг харуулах тоо баримтууд	48
<b>Хавсралт 7.</b> Эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангах тал дээр редакцуудад хүргэх зөвлөмж	51
<b>Хавсралт 8.</b> Бодит мэдээлэл: Эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангах нь	55
<b>Хавсралт 9.</b> Мэдрэмжтэй өнцөг: Жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь	58
<b>Хавсралт 10.</b> Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	60
<b>Хавсралт 11.</b> Сонгогчийн боловсрол ба хэвшмэл ойлголт	63
<b>Хавсралт 12.</b> “Мэдрэмжтэй Мэдээлье” нэгдлийн танилцуулга	65
<b>Хавсралт 13.</b> Жендэрийн нэр томъёоны товч тайлбар	66
<b>ЭХ СУРВАЛЖ</b>	68

# ӨМНӨХ ҮГ

**М**онгол Улс чөлөөт, шударга сонгуулиар дамжуулан төр засгаа тохинуулах иргэн бүрийнхээ эрхийг олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжуудаараа баталгаажуулсан байдаг. Ардчилсан тогтолцоонд шилжиж Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш буюу 1992 оноос хойш Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн, болон орон нутгийн сонгуулийг тус бүр найман удаа зохион байгуулжээ.

Ардчиллын амин чухал хэмжүүр нь ард түмэн сонгосон төлөөллөөрөө дамжуулан эрх мэдлээ хэрэгжүүлэх юм. Парламент бол үндэсний хэмжээний төлөөллийн байгууллага. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их хуралд эмэгтэйчүүд, залуусын төлөөлөл хангалтгүй, байгаагийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөх байхгүй байсаар өнөөдрийг хүрлээ. Хамгийн сүүлийн үеийн статистикийг авч үзвэл 2020 оны Улсын Их хурлын сонгуулиар бүрдсэн УИХ-ын гишүүдийн 80 гаруй хувийг 40-өөс дээш насны эрэгтэйчүүд бүрдүүлж, улсын нийт хүн амыг төлөөлөн шийдвэр гаргаж байна.

Харин 2024 оны УИХ-ын сонгуулиар нийгмийн бүлгүүдийн төлөөлөл болох эмэгтэйчүүд, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо, төлөөлөл бодитоор нэмэгдэх эрхзүйн орчин бий болоод байна. Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж гишүүдийн тоог нэмсэн. Мөн УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулгаар жендэрийн эрх тэгш байдлыг дэмжсэн үзэл баримтлалыг тусгасан зэрэг тогтолцооны томоохон шинэчлэл хийж энэ боломжийг бүрдүүлсэн.

Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн үеэр, ялангуяа сонгуулийн сурталчилгааны хугацаанд иргэдийг бодитой, баримттай, олон ургалч, тэнцвэртэй, нягталж шалгасан мэдээллээр хангаж, тэдэнд мэдээлэлтэй сонголт хийх боломж олгосноороо ардчилалд үнэтэй хувь нэмэр оруулдаг. Тиймээс ч Монголын сэтгүүлчдийн дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болох Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хэрэгжилт

сонгуулийн үед бусад үеэс ч өндөрт тавигддагийн зэрэгцээ тогтолцооны томоохон эрхзүйн шинэчлэлийн хэрэгжилтэд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн гүйцэтгэх үүрэг асар их болоод байна.

Нөгөө талаас бодит байдлыг сурвалжлан мэдээлэхдээ **хэнийг ч ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл ойлголтын золиос болгохгүй байх нь** хэвлэл мэдээл-Елийн мэргэжлийн, ёс зүйн шаардлага. Гэвч сэтгүүл зүйн агуулгад эмэгтэйчүүдийн дуу хоолойг тэнцвэртэйгээр хүргэх, жендэрийн хэвшмэл ойлголтуудыг халах чиглэлээр Монголын төдийгүй олон улсын хэвлэл мэдээлэлд алдаа, дутагдал байсаар байна. 2020 оны сонгуулийн үеийг хамруулан Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хийсэн судалгаанаас үзэхэд улс төрийн мэдээллийн арван эх сурвалж тутмын нэгийг л эмэгтэйчүүд бүрдүүлж байв. Мөн эмэгтэй улстөрчдийг гадаад төрх, хүйс, хувийн амьдрал болон гэр бүлийн байдал зэргээр нь дүрсэлж, улс төрийн байр суурь, үйл ажиллагааг нь хойш тавих хандлага ажиглагдаж байна.

Тиймээс хэвлэл мэдээллийн ёс зүйг сонгуулийн үед хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх “Сонгуулийг мэдрэмжтэй сурвалжлах нь” удирдамжийг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс боловсрууллаа.

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийг хамтран санаачлан, үйл ажиллагааг идэвхжүүлэх тал дээр хамтран ажиллаж байгаа Анлимитэд Медиа групп болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн багийн хандгун талархал илэрхийлье.

Г.Гүнжидмаа  
Хэвлэл мэдээллийн зөвлөлийн  
гүйцэтгэх захирал

# ЯАГААД СОНГУУЛИЙГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖЛАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

*“СОНГУУЛЬ ҮҮССЭН ХИЙГЭЭД ҮРГЭЛЖИЛЖ  
ИРСНИЙ УГ ШАЛТГААН НЬ АРД ТҮМЭН  
УЛС ОРНОО ӨӨРСДӨӨ УДИРДАХ АМИН  
ХЭРЭГЦЭЭ ЮМ.”*

**ГАВЬЯАТ ХУУЛЬЧ Б.ЧИМИД**

**А**рдчиллын амин чухал хэмжүүр нь ард түмэн сонгосон төлөөлөөрөө дамжуулан эрх мэдлээ хэрэгжүүлэх юм. Гэвч Монгол Улсын иргэн бүр хэн байхаасаа үл хамааран Үндсэн хуульд заасан сонгох, сонгогдох эрхээ бүрэн эдэлж чадаж байна уу?

Манай улсын нийт хүн амын 51 хувийг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн төлөөлөл УИХ-ын гишүүдийн 17 хувь, ИТХ-ын төлөөлөгчдийн 27 хувийг л бүрдүүлж байна. Мөн 1993 оноос хойш болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн найман удаагийн сонгуульд нийт 22 хүн нэр дэвшсэнээс ганц нь л эмэгтэй байв. Үүний зэрэгцээ 40-өөс доош насныхан нийт хүн амын 62 хувь, сонгуулийн насны иргэдийн 52 хувийг эзэлж байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй 115115 иргэдийн төлөөлөл улс төрийн шийдвэр гаргах бүх түвшинд туйлын хангалтгүй хэвээр. Тиймээс нийгмийн олон янзын бүлгийн улс төрийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх нь ардчиллыг бүрэн утгаар хэрэгжүүлэх, хэнийг ч орхигдуулахгүйгээр хамтдаа шийдвэр гаргах, улмаар тогтвортой хөгжилд хүрэх нэн чухал асуудал билээ.

Юуны түрүүнд хүн төрөлхтний тэн хагасыг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг хангахгүйгээр ардчиллыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүйг дэлхий даяар хүлээн зөвшөөрөөд 30 гаруй жил болж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, эрэгтэй эмэгтэй хүмүүс хамтдаа тэгш эрхтэй оролцох нь ардчиллын салшгүй чухал эрх болохыг олон нийтэд ойлгуулах, эрэгтэй эмэгтэй хүмүүсийг тэгш эрхтэй оролцуулахын тулд оролцоо нь доогуур байгаа бүлгийг оролцоог нэмэгдүүлэхээс эхлээд улстөрч эмэгтэйчүүдийг хэвлэл мэдээллээр дорд үзсэн байдлаар гаргахаас зайлсхийх хүртэл хэвлэл мэдээлэл онцгой үүрэг хүлээх тухай Олон улсын парламентын холбоо 1994 онд гаргасан Улс төрийн амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцооны тэгш бус байдлыг арилгах үйл

ажиллагааны төлөвлөгөөндөө тэмдэглэсэн байдаг.

Учир нь 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1979 оны Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах НҮБ-ын конвенц, 1966 оны Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын гэрээ конвенцын хэрэгжилт хангалтгүй байсаар байсан юм. Харин 1995 оны намар 189 орны 40,000 гаруй төлөөлөгч, нийгмийн идэвхтэн Бээжин хотод чуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн асуудлаарх НҮБ-ын бага хурлын үеэр дээрх зөвлөмжийг онцгойлон авч үзжээ. Тодруулбал, үүний үр дүнд баталсан даян дэлхийн охид, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах, нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрх, боломжийг нь нэмэгдүүлэх Бээжингийн тунхаглал болон түүнийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан 12 шийдвэрлэх чиглэлийн нэг нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо байв. Мөн хэвлэл мэдээллийг бас нэг шийдвэрлэх чиглэл болгон онцолж, тус салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдлыг дэмжиж, хэвшмэл ойлголтуудыг халах гэсэн стратегийн хоёр зорилго тавьжээ. Үүнээс хойш жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх ажлууд олон улсын хэмжээнд хэрэгжсэн ч ахиц дэвшил чамлалтай байгаа юм.

Энэ бүхнээс үүдэн эмэгтэйчүүд, улс төр, хэвлэл мэдээллийн хоорондын уялдаа холбоог судлах эрдэмтэн, судлаачдын сонирхол сүүлийн 30 гаруй жил илт нэмэгдэж ирсэн. Энэхүү сэдвээр хийсэн судалгаанд ихэнхдээ асуудал хоёр талтайг онцолдог.

Нэгдүгээрт, эмэгтэй улстөрчдийг хэвлэл мэдээллээр гаргах нь цөөн. Тухайлбал, 1990-ээд оны АНУ-ын сонгуулийн үеэр хийсэн томоохон судалгаануудаар эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр гаргахдаа хойрго байдгийг баталсан нь 1978 онд профессор Жеорж Гербнерийн нэрлэсэн “symbolic annihilation” буюу “төлөөллийн огоорол” томьёоллыг

баталгаажуулжээ. Энэ нь хүйс, арьс өнгө зэргээс хамаарч нийгмийн зарим бүлгийн төлөөллийг хэвлэл мэдээллээр хавьгүй бага гаргагчийг, тэр нь эргээд тэгш бус байдлыг өөгшүүлдгийг тодорхойлсон ойлголт юм. Үүнээс хойш дэлхийн өнцөг булан бүрд эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр бага гаргагчийг бататгах судалгаа одоог хүртэл хөвөрсөөр. Монгол Улсын хувьд 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр улс төрийн мэдээллийн арван эх сурвалж тутмын нэгийг л эмэгтэйчүүд бүрдүүлж байв.

Хоёрдугаарт, эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр гаргалаа ч хэвшмэл ойлголтын дагуу дүрслэх нь элбэг байдгийг сүүлийн үеийн судалгааны ололтууд нотолж байна. Тэдний улс төрийн байр суурь, үзэл бодлоос илүүтэй гадаад төрх, хувийн амьдрал, хүйсийг онцолж, тодорхойлох нь элбэг байдгийг Монголын хэвлэл мэдээлэлд хийсэн олон төрлийн судалгааны үр дүн нэгэнт харуулж байгаа билээ.

Иймд хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн олон янзын бүлгийн дуухоолойг олон нийтэд хүргэх чиглэлээр илүү мэргэжлийн, ёс зүйтэй ажиллах шаардлагатай нүүр тулж байна.

Нөгөөтэйгүүр, жендэрт суурилан ялгаварлан гадуурхалгүй байх нь сэтгүүлчдийн мэргэжлийн, ёс зүйн стандартын чухал шаардлага юм. Монголын Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын гуравдугаарт “Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй” хэмээгээд 3.2-т “Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ” гэж заасан.

Нэн ялангуяа сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэл ёс зүйн зарчмаа нягт баримтлан ажиллах нь ардчиллыг бэхжүүлэх, ард түмэн олон ургалч, бодит мэдээлэл дээр үндэслэн зөв сонголт хийхэд шууд нөлөө үзүүлдэг билээ. Сонгуулийн үеэр нийгмийн олон янзын дуу хоолой, тэр дундаа төлөөллийн түвшинд цөөнх болж буй эмэгтэйчүүдийн байр суурь, дуу хоолойг орхигдуулах нь мэдээлэлтэй сонголт хийх иргэдийн эрхийг зөрчиж байгаа хэрэг юм.

Сонгууль бол бүхэлдээ бодлогын өрсөлдөөн. Энэ өрсөлдөөнийг шударга явуулахын тулд сэтгүүлчид дөрөв дэх засаглалынхаа үүргийг биелүүлж, хүний эрхийн хийгээд жендэрийн мэдрэмжтэй хандах тухайлбал нэр дэвшигчдэд хүйс рүү чиглүүлсэн асуулт тавихын оронд бодлогын холбогдолтой асуулт тавьдаг байх нь чухал. Хэрэв аль нэг талд үйлчлэх, ёс зүйн алдаа гаргавал сонгууль шударга бус болохыг өөгшүүлж буй хэрэг юм.

Монгол Улсад сүүлийн 30 жилд бий болж буй өөрчлөлт, чиг хандлагыг бодитойгоор тусгаж, улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг

арилгах, тэгш оролцоог хангахад хэвлэл мэдээлэл онцгой үүрэг гүйцэтгэх учиртай.

Ялангуяа хууль эрх зүйн эерэг өөрчлөлтийн дараах 2024 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэл хэрхэн ажиллахаас Монгол Улс төлөөллийн ардчиллаа бэхжүүлж чадах эсэх нь ихээхэн хамаарах юм.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн өнгөрсөн хоёр жилийн хугацаанд хуримтлуулсан туршлага, нөөц хэрэглэгдэхүүн дээр үндэслэн сонгуулийг жендэрийн мэдрэмжтэй мэдээлж, сурвалжлахад дэмжлэг үзүүлэх гарын авлагыг боловсруулж бэлтгэлээ. Гарын авлага нь дараах агуулгыг багтаасан болно. Үүнд:



## СОНГУУЛИЙН ӨМНӨ

Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг сурвалжлахаасаа өмнө анхаарах зүйлс, редакц болон сэтгүүлч бэлтгэлээ хангахад туслах зөвлөгөө, нөөц хэрэглэгдэхүүн



## СОНГУУЛИЙН ҮЕЭР

(Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвээр бүтээл хийх нь)

Бэлтгэл шатанд редакц, сэтгүүлчийн хэрэгжүүлэх алхмууд  
Бүтээл хөгжүүлэлтийн шатанд нэр дэвшигчдийг мэдрэмжтэй илэрхийлж гаргах, эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах, эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтоос зайлсхийх алхмууд, нөөц хэрэглэгдэхүүн  
Бэлэн болсон бүтээлийг үзэгч, уншигчдад хүртээмжтэй хүргэх арга замууд



## СОНГУУЛИЙН ДАРАА

Сонгуулийн үр дүнг жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх, сонгуулийн бус жилд сонгогчдын боловсрол, жендэрийн мэдрэмжийг сайжруулах зорилгоор редакцын хэрэгжүүлэх алхмууд



## ХАВСРАЛТ

Нэмэлт мэдээлэл, материал хэрэглэгдэхүүн, жишээ.

# СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР СЭТГҮҮЛЧ, РЕДАКЦЫН МЭДВЭЛ ЗОХИХ АГУУЛГА

## СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО ГЭЖ ЮУ ВЭ?

*Улс төрийн сонгууль гэж санал хураалт явуулах замаар шийдвэр гаргах үйл явцыг хэлнэ. Сонгууль нь ардчилсан нийгэмд улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх сонгогчдын оролцоо, төлөөллийг хангах нийгмийн зөвшилцлийг хангах ач холбогдолтой.*

Энэ утгаараа сонгуулийн тогтолцоо нь зөвхөн сонгогчдын авсан саналыг суудал хуваарилахад ашиглаж буй арга биш юм. Энэ бол явцуу ойлголт. Сонгууль бол нам эвслийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигч, кампанит ажил, сонгуулийн дүнг багтаасан өргөн хүрээтэй ойлголт. Тиймээс улс төрийн намууд сонгуулийн тогтолцооноос хамаарч ямар мөрийн хөтөлбөр гаргах, хэнийг нэр дэвшүүлэх, сонгуулийн кампанит ажлаа хэрхэн явуулахаа төлөвлөдөг.

Сонгуулийн тогтолцоог мажоритар, пропорционал, мөн энэ хоёрын аль алиныг хэрэглэсэн холимог гэж үндсэндээ гурав ангилж болно. Сонгуулийн холимог тогтолцоог хосолсон (parallel), холимог (mixed) гэж хоёр хуваагддаг. Манайд 2012 оны УИХ-ын сонгуульд сонгуулийн холимог тогтолцооны хосолсон хувилбарыг хэрэглэж байсан. 2023 онд УИХ-ын Сонгуулийн тухай

хуульд нэмэлт өөрчлөлт оруулж сонгуулийн “хосолсон” тогтолцоог дахин ашиглахаар болсон. аливаа улсад яв цав тохирсон сонгуулийн тогтолцоо гэж байхгүй. Сонгуулийн тогтолцооны бүх хэлбэр давуу болон сул талтай. Тиймээс дэлхийн улс орнууд өөрт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс тогтолцооны хувилбарыг сонгодог. Монгол Улсад өнгөрсөн 30 гаруй жил тулгамдаж байгаа сонгогчдын оролцоо, төлөөллийг хангах, намын төлөвшилтийг дэмжих, санал гээгдэхгүй байх, сонгогчдын боловсролыг дэмжих, сонгуулийн зардлыг бууруулах, намуудыг бодлогын өрсөлдөөнд оруулах зорилгоор сонгуулийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

2024 оны УИХ-ын сонгуулийн үеэр сэтгүүлчдийн мэдвэл зохих чухал үйл явдлын хураангуй цаглаварыг “Хавсралт 1”-ээс үзнэ үү.



# 1

## САНАЛЫН ХУУДАСНЫ ТАЛААР ЮУ МЭДЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

**САНАЛЫН ХУУДАС**  
Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн XX дугаар тойргийн XX дугаар хэсэг

XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			XXXXXXXXX нам			
<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input checked="" type="radio"/>	Нэр дэвшигч -X
<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X	<input type="radio"/>	Нэр дэвшигч -X

Та өөрийн сонгохыг хүссэн 1 нам, эвсэлийн нэрийн өмнөх дугуйг дүүргэн будаж саналаа өгнө үү

<input type="radio"/>	А нам	<input type="radio"/>	Г нам	<input type="radio"/>	Е нам	<input type="radio"/>	Н нам
<input type="radio"/>	Б нам	<input type="radio"/>	Д нам	<input checked="" type="radio"/>	Л нам	<input type="radio"/>	О нам
<input type="radio"/>	В нам	<input type="radio"/>	Е нам	<input type="radio"/>	М нам	<input type="radio"/>	Ө нам

Саналын хуудас хоёр хэсэгтэй байна. Саналын хуудасны **дээд** талд мандатын тоогоор тойрогт нэр дэвшигчдийн нэрс, **доод** талд сонгуульд оролцож буй улс төрийн намуудын нэрс байна.

Сонгогч тухайн тойргийн мандатын тооноос илүү эсвэл дутуу нэр дугуйлбал тухайн саналын хуудас хүчингүйд тооцогдохыг сонгогчдод сануулах нь зүйтэй.

Сонгогч тухайн тойрог ногдсон мандатын тооноос хамарч 2-10 нэр дэвшигч болон нэг намын төлөө саналаа өгнө. Жишээ нь, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймаг нийлээд 10 мандаттай нэг том тойрог болсон. Сонгогч 10 мандат дээр нэмэх нь нэг нам, нийлбэр дүнгээр 11 сонголт хийнэ гэсэн үг.

# 2.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ



## УЛААНБААТАРЫН БҮС

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ  
8-Р ТОЙРОГ  
МАНДАТ 5

БАЯНГОЛ ДҮҮРЭГ  
9-Р ТОЙРОГ  
МАНДАТ 3

СҮХБААТАР, ЧИНГЭЛТЭЙ  
10-Р ТОЙРОГ  
МАНДАТ 6

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ  
11-Р ТОЙРОГ  
МАНДАТ 5

ХАН-УУЛ ДҮҮРЭГ  
12-Р ТОЙРОГ  
МАНДАТ 3

БАГАНУУР, БАГАХАНГАЙ,  
НАЛАЙХ  
13-Р ТОЙРОГ  
МАНДАТ 2

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг орон нутагт бүсчилсэн 7, нийслэл Улаанбаатарт 6, нийт 13 байхаар тусгасан. Тодруулбал:

- Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгуудыг нэгтгэн 1-р тойрог;
- Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудыг нэгтгэн 2-р тойрог;
- Баян-Өлгий аймаг 3-р тойрог;
- Булган, Орхон, Хөвсгөл аймгуудыг нэгтгэн 4-р тойрог;
- Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудыг нэгтгэн 5-р тойрог;
- Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг нэгтгэн 6-р тойрог;
- Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудыг нэгтгэн 7-р тойрог;
- Баянзүрх дүүрэг 8-р тойрог; Баянгол дүүрэг 9-р тойрог;
- Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийг нэгтгэн 10-р тойрог;
- Сонгинохайрхан дүүрэг 11-р тойрог;
- Хан-Уул дүүрэг 12-р тойрог;
- Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийг нэгтгэн 13-р тойрог байхаар тооцсон

# 3.

## УИХ-ЫН 126 ГИШҮҮНИЙГ ХЭРХЭН СОНГОХ ВЭ?



### /МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 74.3.3, 74.3.4, 74.3.5/

**БОСГО:** 48 суудлыг босго давсан намуудад хуваахаар хуульд тусгагдсан. Тодруулбал,

Нэг нам дангаараа сонгуульд оролцсон тохиолдолд 4%, хоёр хүртэлх нам эсвэл байгуулсан бол 5%, гурав ба түүнээс дээш тооны намууд эвсэл байгуулбал 7%-ийн саналын босго давснаар суудал хуваарилалтад оролцох эрх үүснэ.

**4%** нэг нам дангаараа

**5%** хоёр хүртэлх нам, эвсэл

**7%** гурав ба түүнээс дээш тооны нам, эвсэл

## ХУВЬ ТЭНЦҮҮЛЭХ ТОМЬЁО

**ИХ ҮЛДЭГДЛИЙН ЗАРЧИМ:** Хуульд заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй

суудал үлдвэл хамгийн их үлдэгдэл буюу хамгийн их бутархай хувьтайгаас нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусах юм.

$$\frac{\text{Босго давсан намуудын авсан нийт саналын тоо}}{48} = \text{Нэг суудалд оногдох дундаж саналын тоо}$$



$$\frac{\text{А намын авсан нийт саналын тоо}}{\text{Нэг суудалд оногдох дундаж саналын тоо}} = \text{А намын эзлэх нийт суудлын тоо}$$

“

**ХУВЬ ТЭНЦҮҮЛЭХ  
БУЮУ  
ЖАГСААЛТЫН  
СУУДЛЫГ ИХ  
ҮЛДЭГДЛИЙН  
АРГААР  
ХУВААРИЛНА.**

”

# 1. СОНГУУЛИЙН ӨМНӨ

**Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг сурвалжлахаасаа өмнө юуг анхаарах вэ?**

- Редакц юу хийх ёстой вэ?
- **Нөөц хэрэглэгдэхүүн:** Эх сурвалжийн мэдээллийн сан
- Сэтгүүлч юу хийх ёстой вэ?
- Жендэрийн тэгш бус байдлын талаар ойлголтоо гүнзгийрүүлэх
- Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

# УЛС ТӨР ДЭХ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫГ СУРВАЛЖЛАХААСАА ӨМНӨ ЮУГ АНХААРАХ ВЭ?

**Х**эвлэл мэдээлэл ардчилсан үйл явцын ил тод байдлыг хангахад чухал үүрэгтэй. Үүнийг ихэвчлэн “хоточ нохой”-н үүрэг гэж нэрлэдэг. Нэр дэвшигч тодруулах, бүртгэх, саналын хуудас хэвлэх, санал хураах, санал тоолох, дүн танилцуулах хүртэлх сонгуулийн явцад, мөн Сонгуулийн төв байгууллага, салбар хороод үүргээ шударгаар биелүүлж буй эсэхэд хяналт тавих нь хэвлэл мэдээллийн үүрэг юм. Үүнээс гадна улс төрийн намууд, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, үйл ажиллагаанд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэлтэй шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай. Энгийнээр хэлэхэд, ардчилсан сонгуулийн үеэр хоорондоо нягт холбоотой гурван эрхийн асуудлыг зайлшгүй бодолцох ёстой. Үүнд:

- Бүрэн дүүрэн мэдээлэл дээр үндэслэн сонголтоо хийх сонгогчдын эрх;
- Олон нийтэд бодлогоо хүргэх нэр дэвшигчдийн эрх;
- Хэвлэл мэдээллийн мэдээлэх болон нийтийн эрх ашгийн асуудлаар редакцын байр сууриа илэрхийлэх эрх.

Бүх талын эрх ашгийг хангахын тулд хэвлэл мэдээлэл бие даасан, чөлөөт байдлаар үйл ажиллагаа явуулах онцгой эрх эдлэхийн зэрэгцээ асар чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Үүний зэрэгцээ төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхийн тулд хэвлэл мэдээлэл сонгуулийг жендэрийн мэдрэмжтэй мэдээлж, сурвалжлах шаардлага тулгарч байна. Ингэхдээ юун түрүүнд улс төр дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвийг онцолж, үүнд нөлөөлж байгаа учир шалтгааныг тайлбарлаж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тал дээр шийдвэр гаргагчид үүрэг, амлалтаа биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих нь чухал.

Хавсралт 2 хуудас 42

# Редакц юу хийх ёстой вэ?

Нийгмийн олон бүлгийн дууг хоолойг тэнцвэртэй хүргэх, жендэрийн мэдрэмжийг бэхжүүлэхэд дан ганц сэтгүүлчийн хүчин чармайлт хангалтгүй юм. Үүнийг өдөр тутмын үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгон төлөвшүүлэхэд редакцын манлайлал нэн чухал. Иймд редакц жендэрийн мэдрэмжийг аливаа контент, сэтгүүл зүйн бүтээлдээ тусгах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход чиглэсэн бодлогын баримт бичигтэй байх шаардлагатай. Мөн дараах алхмуудыг хэрэгжүүлээрэй.

## 1. Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн сургалт зохион байгуулах

Редакцын сэтгүүлзүйн бүтээлийн чанарыг сайжруулж сэтгүүлч, уран бүтээлчидээ жендэрийн мэдрэмжтэй бүтээл бэлтгэхэд нь туслах зорилгоор редакцдаа танхимын болон цахим сургалт зохион байгуулахыг зөвлөж байна. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс редакцын сургалт, уулзалт хийх, эсвэл сургагч багш нарт зориулсан гарын авлагыг нөөц хэрэглэгдэхүүний хамт редакцын чадавх бэхжүүлэх ажлыг дэмжих боломжтой.

## 2. Гарааны судалгаа хийх

Юуны түрүүнд редакцынхаа одоогийн бэлтгэж буй улс төрийн агуулга дахь эх сурвалжуудын хэчнээн хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг тооцоолж гаргаснаар та бүхний бүтээж буй агуулга хэр жендэрийн тэнцвэртэй байгааг олж мэднэ.

## 3. Зорилгоо тодорхойлох

Сонгуулийн үеэр сэтгүүл зүйн бүтээлдээ эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц зорилго

тавиарай. Тухайлбал, танай редакцын бэлтгэж буй улс төрийн мэдээний нийт эх сурвалжийн 30 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байвал сонгуулийн үеэр үүнийг 40 хувьд хүргэх гэх мэтээр зорилго тавих.

## 4. Зорилгоо санаачилга болгон зарлах

Санаачилгадаа тохирсон нэр өгөх нь редакцын ажилтнууд төдийгүй бусад байгууллага, хамгийн гол нь танай уншигч үзэгчид ойлгож, дэмжихэд тусална. Жишээ нь, “Bloomberg” “**Шинэ дуу хоолой**”, BBC 50:50, Монголын GoGo.mn мэдээллийн сайт “**Тэнцвэр**” нэртэй санаачилга гарган олны анхаарлыг татаж байсан.

## 5. Эх сурвалжийн бүртгэл хөтлөх

Агуулгад жендэрийн тэнцвэрт байдлыг хангахын тулд эх сурвалжуудаа хүйсээр ангилах нь мониторингийн хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм. Бүртгэл хөтлөхдөө дараах **загвар хүснэгтийг** ашиглах боломжтой. Ингэхдээ эх сурвалжуудаа улс төр, эдийн засаг, технологи, уул уурхай, хөдөө аж ахуй гэхчлэн салбар тус бүрээр ангилах нь тохиромжтой юм.



## Загвар хүснэгт

№	Овог	Нэр	Байгууллага	Албан тушаал	Мэргэжил	Хэвлэл мэдээлэлд ярилцлага, мэдээлэл өгөх өнцөг/сэдэв	Энэ чиглэлээр ажилласан туршлага /жил/	Утас	И-мэйл	Сошиал холбоос	Өмнө нь хэвлэлд яриа өгч байсан бол линкийг энд оруулна уу	Зөвшөөрөл авсан эсэх
1.												
2.												
3.												

### 6. Эх сурвалжийн дата сан бүрдүүлэх, ашиглах

Сэтгүүлчид ашиглахад хялбар болгох үүднээс эмэгтэй эх сурвалжуудтай холбоо барих жагсаалт буюу дата сан гаргаж өгөөрэй. Ингэснээр эх сурвалж эрж хайх цаг хугацааг хэмнэх, сэтгүүлчдийн ажлыг илүү хялбаршуулах боломжтой.

### 7. Хамтын ажиллагаа өрнүүлэх

Сонгуулийн үеэр эмэгтэйчүүдийн дуу хоолойг гаргах зорилгоор улс төрийн намууд, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

Дэлгэрэнгүй зөвлөгөөг “Хавсралт 7”-оос уншина уу.

Хавсралт 7 хуудас 51

### НӨӨЦ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН. ЭХ СУРВАЛЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлээс Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээтэй хамтран 2022 оны хавар “Эмэгтэй эх сурвалжийн мэдээллийн сан” бүрдүүлэх аян зарлаж, сэтгүүлчдийн дунд хакатон зохион байгуулсан билээ. Үүнд улс төр, эдийн засаг, технологи, уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг эрэгтэйчүүд давамгайлсан салбарын талаар ярих эмэгтэйчүүд, мөн жендэрийн сэдвээр ярих эрэгтэй эх сурвалжийн мэдээллийг бүрдүүлэхдээ тэднээс хэвлэл мэдээлэлд ярилцлага, мэдээлэл өгөх зөвшөөрөл авснаараа онцлог юм.

**500 гаруй эх сурвалжийн мэдээлэл** бүхий энэхүү дата санг доорх линкээр хүсэлтээ илгээн авч ашиглах боломжтой.

Линк: <https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSdItEkAdNSOcGG-CwIQVCTROWZrdcYdzATNmniCa-IMowy9cDQ/viewform>

# Сэтгүүлч юу хийх ёстой вэ?



## 1. Жендэрийн тэгш бус байдлын талаар ойлголтоо гүнзгийрүүлэх

Юунытүрүүндүлстөрийншийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлын талаар ойлголттой болох нь чухал бөгөөд тус гарын авлагаас та хангалттай мэдээлэл, ойлголт авах болохын зэрэгцээ энэ сэдвээр сургалт, семинарт хамрагдаж болно. Мөн [tentsuu.mn](https://tentsuu.mn) платформын “Мэдээллийн сан” хэсгээс шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш/тэгш бус байдлын сэдвээр “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн сэтгүүлчдийн гаргасан бүтээлүүдийг харах нь өнцгөө тодорхойлоход тань тусална гэдэгт итгэлтэй байна. Үүнээс гадна эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийн талаар “Хавсралт 3”-аас нэмэлт мэдээлэл аваарай.

Хавсралт 3

хуудас 44



## 2. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

### а. Хууль эрх зүйн шинэчлэлийг судлах

Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдал манай улсад тулгамдсан асуудал хэдий ч үүнийг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлэх хууль эрх зүйн таатай орчныг 2023 онд бүрдүүлж чадсан. Иймд нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ хууль эрх зүйн орчны шинэчлэлээс эхэлж болно.

ТУХАЙЛБАЛ,

- 2023 оны тавдугаар сарын 31-нд Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “**Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй**” байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн **холимог тогтолцоогоор** явуулна. Улсын Их Хурлын **далан найман** гишүүнийг олныг төлөөлөх, **дөчин найман** гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” хэмээн өөрчлөн найруулсан.

- 2023 оны зургаадугаар сарын 16-нд УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа хүйсийн квотыг 2024 оноос **30 хувь**, 2028 оноос **40 хувь** хүргэхээр болсон юм. Үүний зэрэгцээ нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн



Хавсралт 4

хуудас 45

болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглож, 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг хуульчилснаар эмэгтэйчүүдэд ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлсэн билээ. Эдгээрийг зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг Сонгуулийн төв байгууллага бүртгэж авахгүй гэж заасан

Хавсралт 4 хуудас 47

### б. Улс төрийн намуудын амлалттай танилцах

2023 оны дөрөвдүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хотод болсон “Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөллийг хангах амлалт” олон улсын форумын үеэр улс төрийн 10 намын удирдлага “Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөллийг хангах улс төрийн намын амлалт-д” нэгдэж, гарын үсэг зурсан. **Түүнчлэн МАН, АН, ХҮН гэсэн улс төрийн гурван нам жендэрийн тэгш байдлыг хангах, гишүүд, дэмжигчдийнхээ оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх бодлогын баримт бичгээ боловсруулж, нийтэд зарласан.**

Ингэснээр Монгол Улсад төлөөллийн ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй институт болохын хувьд шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг хангахыг дэмжиж буйгаа илэрхийлж, оролцох, төлөөлөх нь иргэн бүрийн эрхэм нандин үнэ цэн, хүний үндсэн эрх болохыг цохон тэмдэглэсэн. Иймд улс төрийн намууд хуулиар хүлээсэн үүргээ төдийгүй олон нийтэд өгсөн амлалтаа бодитойгоор биелүүлж чадаж байгаа эсэхэд хяналт тавих нь мэдээ, нийтлэл бэлтгэх бас нэгэн үнэ цэнтэй өнцөг болох юм.

Хавсралт 5 хуудас 47

### с. Улс төр дэх жендэрийн тэгш байдлыг харуулах тоо баримтуудтай танилцах

• Улс төр дэх жендэрийн тэгш байдлын үзүүлэлтүүдийг Монгол болон дэлхий дахинаар харьцуулан харахыг хүсвэл дараах эх сурвалжуудад хандаарай.

• Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг [Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын индекс](#), [Хэвлэлийн эрх чөлөөний индекс](#), [Ардчиллын индекс](#), [Авлигын төсөөллийн индекс](#),

• Олон улсын парламентын холбооноос сар бүр шинэчлэн гаргадаг [Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалт](#),

• Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, мөн орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон гишүүдийг хүйс, сонгуулийн жилээр нь харах,

• 2024 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улс Жендэрийн зөрүүтэй байдлын индексээр 146 орноос **80 дугаарт**, Хэвлэлийн эрх чөлөөний индексээр 180 орноос **88 дугаарт**, Авлиганы индексээр 180 улсаас **121 дүгээрт**, Ардчиллын индексээр **81 дүгээрт**, Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтад 189 орноос **133 дугаарт** тус тус жагсаж байна. Эдгээр эх сурвалжийн мэдээлэл тогтмол шинэчлэгддэг тул та хамгийн сүүлийн үеийн хувилбарыг уншиж байгаа эсэхээ давхар нягтална уу. Мөн “Хавсралт 6”-аас Жендэрийн зөрүүтэй байдлын индекс, Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтад Монгол Улс хэддүгээрт эрэмбэлэгдсэнийг дэлгэрүүлэн үзээрэй. Түүнчлэн Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуулийн үр дүнг багцлан харуулав.

Хавсралт 6 хуудас 48



Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын баримт бичгээ батлав.



“Democracy Rising: Women” форумыг зохион байгуулж, жендэрийн бодлогоо зарлав.



Эмэгтэй манлайлагчдыг дэмжих “ХҮН 50:50” бодлогоо зарлав.



# 2.

## СОНГУУЛИЙН ҮЕЭР



- Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвээр бүтээл хийх нь

- **БЭЛТГЭЛ ШАТ**

- Редакцын хэрэгжүүлэх 7 алхам

- Сэтгүүлчид өгөх зөвлөгөө

- **БҮТЭЭЛ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ШАТ**

- Эх сурвалжийн гурван түвшин

- Эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах алхмууд

- Эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтоос зайлсхийх **ЗУРГААН АЛХАМ**

- Эмэгтэй нэр дэвшигчийн зураг, дүрсийг авахдаа гаргадаг түгээмэл алдаанаас зайлсхийх нь

- Эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголтыг эвдэхэд туслах арга замууд

- Хүйс үл хамааран нэр дэвшигчдийг хэрхэн мэдрэмжтэй гаргах вэ?

- **БҮТЭЭЛ БЭЛЭН БОЛСНЫ ДАРАА**

- Редакц, сэтгүүлч, юу хийх ёстой вэ?

# УЛС ТӨР ДЭХ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫН СЭДВЭЭР БҮТЭЭЛ ХИЙХ НЬ

**С**этгүүл зүйн бүтээлээр дамжуулан нийгмийн олон янзын төлөөллийн тулгамдсан асуудал, ашиг сонирхол, үзэл бодол, байр суурийг иргэдэд хүргэх нь асар чухал. Нэн ялангуяа сонгуулийн үеэр бүтээл хийхдээ эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах, ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголтоос зайлсхийх нь сэтгүүлчдийн онцгойлон чухалчлах мэргэжлийн хийгээд ёс зүйн чухал стандарт юм.

## Тиймээс энэ бүлэгт:

- Бэлтгэл шатанд сэтгүүлч, редакцад өгөх зөвлөгөө,
- Бүтээл хөгжүүлэлтийн шатанд нэр дэвшигчдийг хүйсээс үл хамааран мэдрэмжтэй гаргах, эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах алхмууд
- Мөн эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтоос зайлсхийх аргуудыг хүргэх болно.
- Эх сурвалжийн хүйсийн тэгш бус байдлын талаар дэлгэрүүлэн унших бол “Хавсралт - 8”-ыг үзнэ үү.

Хавсралт 8 хуудас 55





## БЭЛТГЭЛ ШАТ

# Редакцын хэрэгжүүлэх 7 алхам



## 1. Бүтээлээ тогтмолжуулах

Олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг татаж, үр нөлөө үзүүлэхийн тулд редакцаас төлөвлөн тусгай булан, цуврал зэргийг гаргаж болно. Тухайлбал, “Зууны мэдээ” сонин “Эмэгтэйчүүдийн манлайлал”, “Хэвшмэл ойлголтоо өөрчилъе” сэдэвт булан нээж, тогтмол бүтээл гаргаж эхэлсэн байдаг.



## 2. Эх сурвалжаа хамгаалах

Онлайн орчинд эх сурвалж болсон эмэгтэйчүүдийг сэтгэгдлээр гутаах, доромжлох тохиолдол түгээмэл байдаг. **Тиймээс эмэгтэй эх сурвалж мэдээний сэтгэгдлийг хаалгах хүсэлт тавьсан тохиолдолд редакц уян хатан хандах, хүсэлтийг хүлээн авах зохицуулалт бий болгох хэрэгтэй.**



## 3. Сэтгүүлчдийнхээ оролцоог дэмжих

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагууд шилдэг бүтээл шалгаруулах уралдаан, тэтгэлэг зэргийг зохион байгуулдаг болоод байна. Ийм боломжуудын талаар мэдээлэлтэй байж, сэтгүүлчдээ оролцохыг дэмжиж байгаарай. “Мэдрэмжтэй мэдээлэл” нэгдлийн гишүүн болж, фэйсбүүк групп болон пэйж хуудсыг дагаснаар шинэ боломжуудын талаарх мэдээллийг хялбар авах боломжтой.

## Сэтгүүлчид өгөх зөвлөгөө



### Тоон болон чанарын мэдээллүүдийг цуглуулж дүн шинжилгээ хийх

Хүйсийн ялгаатай байдлыг бий болгож буй улс төр, эдийн засаг, нийгэм соёлын нөхцөл байдал, хүчин зүйлүүдийн талаар судалж, тоон болон чанарын мэдээллүүдийг цуглуулсан дүн шинжилгээ хийгээрэй. Үүнийг хийх хамгийн хялбар бөгөөд үр дүнтэй арга нь жендэрийн чиглэлээр гарсан судалгааны тайлангуудыг гарчиглах юм. Эдгээр судалгаа нь чухал, шинэлэг мэдээллийг агуулдаг ч олон нийтэд төдийлөн хүрээгүй байдаг учраас шинэ өнцөг, хадаас сэдэв гаргах боломж үргэлж байдаг. Та дараах мэдээллийн сангуудаас ач холбогдолтой судалгааны тайлан, дата мэдээллийг авах боломжтой:

- “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд бүтээсэн [tent-suu.mn](https://tent-suu.mn) платформ.
- Жендэрийн үндэсний хорооны [ncge.gov.mn](https://ncge.gov.mn) цахим хуудасны “Ном хэвлэл”, “Судалгаа” цэс.
- Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг мэдээллийн платформ <https://genderhub.mn/>.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://1212.mn>.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн вэб сайт <https://www.mediacouncil.mn/>.



### Мэргэжилтнүүдэд хандаж, зөвлөгөө авах

Өнцгөө нарийвчлан тодорхойлохын тулд тухайн сэдвийг сайн мэдэх мэргэжилтнүүдэд хамгийн түрүүнд хандаж, зөвлөгөө аваарай. Тэд таны бүтээлд чухал эх сурвалж болохоос гадна хэрэгтэй дата мэдээллээ олж авах, бусад

эх сурвалжтай холбоо тогтооход тус болно. Жендэрийн үндэсний хороонд хандан жендэрийн үндэсний шинжээчдийн холбоо барих мэдээллийг авч болно. Мөн МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ, Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд зэрэг ТББ-д ажилладаг мэргэжилтнүүд, их дээд сургуулийн багш, судлаачдад хандах нь тохиромжтой.

## Хандаж болох байгууллагууд (жишээ)

Их сургуулиуд	Төрийн байгууллагууд	Иргэний нийгмийн байгууллагууд	Улс төрийн намын дэргэдэх судалгааны байгууллагууд
МУИС-ийн Жендэр судлалын тэнхим	Жендэрийн үндэсний хороо	МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ	МАН-ын дэргэдэх Хүний эрх - Дэвшилтэт бодлогын хүрээлэн
МУИС-ийн Эдийн засгийн тэнхим	Хүний эрхийн Үндэсний Комисс	Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд	Стратеги академи
МУБИС	Үндэсний статистикийн хороо	Хэвлэл мэдээллийн зөвлөл	Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоо
ШУТИС	Сонгуулийн ерөнхий хороо	Монголын эмэгтэйчүүдийн холбоо	



## Бэлэн нөөц хэрэглэгдэхүүн, гэрэл зургийн нээлттэй санг ашиглах

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо сэдвээр бүтээл хийхэд ашиглаж болох гэрэл зураг, өгөгдлийн дүрслэл хомс байдгийг бидний туршлага харуулсан юм. Энэ бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлээс **МРА агентлагтай** хамтран улс төрд хамтатгаж жендэрийн тэгш, тэгш бус байдлын сэдвээр бүтээл хийж буй сэтгүүлч, редакцууд үнэ төлбөргүй ашиглах боломжтой гэрэл зургийн нээлттэй санг үүсгэсэн. Түүнчлэн **“Тунгаахуй өгөгдлийн урлан”**-гийн хамт олон “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн үйл ажиллагааг дэмжиж, шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвээр хийсэн өгөгдлийн дүрслэлүүдээ сэтгүүлч, редакцууд үнэ төлбөргүйгээр ашиглах боломж бүрдүүлсэн.

### НӨӨЦ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН. ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛИЙН САН

Датаг боловсруулж, дүн шинжилгээ хийж, ойлгомжтой харуулсан өгөгдлийн дүрслэлийн сангаас та бүхэн өөрийн бүтээлдээ тохирохыг нь сонгож авах боломжтой бөгөөд ашиглахдаа “Тунгаахуй өгөгдлийн урлан”-г эх сурвалжаар дурдахаа мартуузай.

Хавсралт 6 хуудас 50

### НӨӨЦ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН. ГЭРЭЛ ЗУРГИЙН НЭЭЛТТЭЙ САН

МРА агентлагийн [“Мэдрэмжтэй мэдээлье” гэрэл зургийн нээлттэй сангаас](#) зураг авч ашиглахдаа эх сурвалжаа “Мэдрэмжтэй мэдээлье гэрэл зургийн нээлттэй сан” гэж зааж өгөхөө мартуузай.



Жишээ: “Үндэстний тойм” сэтгүүл “Мэдрэмжтэй мэдээлье” гэрэл зургийн нээлттэй сангаас бүтээлдээ ашигласан нь



## Ашиглах үг, хэллэгээ анхаарах

Тухайлбал, “эмэгтэйчүүдийн квот” гэж бичих нь зохимжгүй юм. Учир нь, квот бол зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан биш, шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэгш төлөөллийг хангах арга хэрэгсэл учраас хүйсийн квот гэдэг нэршил ашиглана. Мөн сэтгүүлчид үг давтагдахаас зайлсхийх зорилгоор нэр дэвшигч эмэгтэйчүүдийг “хүүхнүүд”, “бүсгүйчүүд” гэх нь утга санааны хувьд зохимжгүй байдаг. Нэн шаардлагатай биш л бол эмэгтэй нэр дэвшигчдийн хүйсийг тодотгох шаардлагагүй.



## БҮТЭЭЛ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ШАТ

Та тодорхойлсон сэдэв, өнцгийнхөө хүрээнд мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, холбогдох тоон болон чанарын мэдээллүүдэд дүн шинжилгээ хийсэн бол гол ажилдаа ороход бэлэн болсон гэсэн үг юм. Бүтээл хөгжүүлэлтийн шатанд сэтгүүлчийн зайлсхийх болон баримталбал зохих зүйлсийг дараах байдлаар тусгалаа.

# Эх сурвалжийн гурван түвшин

Аман эх сурвалжийг үндсэн гурван бүлэгт хувааж үздэг бөгөөд үйл явдал, нөхцөл байдлын талаар аль болох бодитой мэдээлэхийн тулд эдгээр гурван түвшний эх сурвалжаас мэдээлэл авах нь чухал. Үүнд:





# ЭХ СУРВАЛЖИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛХМУУД

Монгол төдийгүй дэлхий дахинд эмэгтэй нэр дэвшигчдийг хэвлэл мэдээллээр бага гаргадаг, гаргахдаа хэвшмэл ойлголтын дагуу дүрслэх нь элбэг байдгийг сүүлийн үеийн судалгааны ололтуудад тулгуурлан өмнөх бүлэгт дэлгэрэнгүй дурдсан. Иймд, хэвлэл мэдээллийн байгууллагууд бүтээл гаргахдаа эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах, эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголтыг эвдэхэд хүчин чармайлт гаргах шаардлагатай тул сэтгүүлч, редакц өдөр тутамдаа хэрэгжүүлж болох зөвлөгөөг энд дэлгэрүүлэн хүргэж байна.

## Зорилгоо тайлбарлах



Улс төрийн болон төрийн байгууллагын хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх эрх мэдэл бүхий хүмүүс ихэвчлэн өндөр албан тушаалтай эрэгтэйчүүд байдаг. Тухайн байгууллагын хэвлэл мэдээллийн төлөөлөгч яагаад заавал эмэгтэй хүнээс ярилцлага, мэдээлэл авах гээд байгааг тань төдийлөн ойлгохгүй байж болно. Иймд та бэлтгэж буй мэдээ, сурвалжилгаараа дамжуулан хэвшмэл ойлголтыг эвдэж, нийгмийн хүлээлтээс өөр дүр зургийг бий болгох, эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахыг зорьж байгаагаа тайлбарлаарай.

## Сэдвийн ач холбогдлыг таниулах



Эмэгтэй экспертүүд олны анхаарлын төвд орох дургүй, эсвэл өөрөөсөө илүү ярих эрэгтэй хүн санал болгох нь элбэг. Энэ үед зорилгоо тодорхой танилцуулж, олон нийтэд хэрэгтэй мэдээлэл өгөхөд тухайн хүний үзэл бодол, дүн шинжилгээ ямар ач холбогдолтойг ойлгуулаарай.

## Айдас, санаа зовнилоо давж гарахад нь туслах



Хэвлэл мэдээлэлд өмнө нь ярилцлага өгч байгаагүй эмэгтэйчүүдэд энэ нь сүрдмээр зүйл мэт санагдах нь бий. Нэгүг л буруу зөрүү хэлчихвэл харамсаж мэднэ гэж айж байж магадгүй. Түүнд найрсаг хандаж, хэрхэн ажилладгаа танилцуулаарай. Хүсвэл яриагаа дахин бичүүлж, мэдээллээ урьдчилан бэлтгэж болно гэдгийг сануулаарай. Мэдээ, нийтлэлийг шууд яриа аваад л цацчихдаггүй, урьдчилан боловсруулж, хянуулсаны эцэст нийтэлдэг талаар тайлдбарлаж ойлгуулахад илүүдэхгүй. Хэрэв шаардлагатай бол нийтлэхээсээ өмнө өөрт нь харуулж, хянуулах талаар зөвлөлдөөрэй. Мөн ямар сэдвээр, хэр их мэдээлэл авах шаардлагатай байгаагаа тоймлон хэлж өгөх нь мөн тустай. Ингэснээр эх сурвалж тань мэдээллээ бэлтгэж, айж сандрахаа ч болино.

## Мэргэжлийн, ёс зүйтэй гэдгээ ойлгуулах



Тухайн эх сурвалж өмнө нь хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөхөд гол утга санааг нь гаргаагүй, эсвэл яриаг нь гуйвуулсан зэргээр итгэлийг нь алдсан байж болно. Хэрэв тийм бол та болон танай редакц мэргэжлийн, ёс зүйтэй гэдгээ тайлбарлаж ойлгуулаарай.

# Эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтоос зайлсхийх ЗУРГААН АЛХАМ

# 1.

## **Хувийн нууцад хүндэтгэлтэй хандах, бусдыг гүтгэхгүй байх:**

Хэвлэл мэдээлэл эмэгтэй улстөрч, нэр дэвшигчдийн хувийн амьдралын талаар сурвалжлан гаргах нь нэмэгдсэн гэж “Жендэр, улс төр ба мэдээ: Гурван талын тоглоом” номын зохиогч Карен Росс тэмдэглэжээ. Ийм жишэг Монголд ч бий. Тиймээс та Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тусгасан хувийн нууцад хүндэтгэлтэй хандах, бусдыг гүтгэхгүй байх үүргээ биелүүлснээр энэ алдаанаас зайлсхийх боломжтой.



# 2.

## **Нэр хоч өгөх, дорд үзсэн агуулга, дүрслэл ашиглахгүй байх:**


Эмэгтэй улстөрч, нэр дэвшигчдэд элдэв нэр хоч өгөх байдлаар дорд үзэх стратегийг хэвлэл мэдээлэл түгээмэл ашиглахгүйг мөн Карен Росс онцолжээ. Үүнийг сургалтын үеэр ярихад оролцогчид эрэгтэйчүүдэд ч бас нэр хоч өгдгийг сануулах нь бий. Хэдий тийм ч эмэгтэй болон эрэгтэй улстөрчдийн нэр хочийг хэлүүлж, самбар дээр тэмдэглэхэд эмэгтэйчүүдийнх илт олон байдаг. Үүний зэрэгцээ, эмэгтэйчүүдэд өгсөн нэр хоч доромжилсон, тохуурхсан агуулгатай байх нь элбэг. Бусдыг доромжлохгүй байхыг мөн л ёс зүйн зарчимд тусгасан байдаг бөгөөд мэргэжлийн сэтгүүлч хэзээ ч ийм алдаа гаргах ёсгүйг сайтар анхаараарай.



# 3.

## **Гэр бүлийн амьдралыг нь тодотгохоос зайлсхийх:**

Эмэгтэй нэр дэвшигчдийн гэр бүлийн амьдралыг тодотгож, тэднийг улс төрийн ажлаа ээж, эмээгийн үүрэг хариуцлагатайгаар хавсран хийж чадах эсэхийг асуудаг нь түгээмэл байдгийг профессор Виржиния Гарсия Боудоу онцолжээ. Монголд ч мөн эмэгтэй нэр дэвшигчийг сайн эхнэр, ээж мөн эсэхийг чухалчилдаг. Иймд, нэр дэвшигч эмэгтэйн талаар нийтлэл/нэвтрүүлэг бэлтгэхдээ хэдэн хүүхэдтэй, хэр сайн ээж вэ гэдэг талаар шаардлагатай биш л бол оруулах хэрэггүй.



Олон улсад болон Монголд хийсэн судалгааны ололтууд дээр үндэслэн эмэгтэй нэр дэвшигчдийг хэвшмэл ойлголтын дагуу харуулдаг нийтлэг зургаан алдаа болон тэдгээрээс зайлсхийх арга замыг хуваалцъя.

# 4.

## **Нөлөө бүхий эрчүүдийн дагуул дүрээр гаргахгүй байх:**

Хэвлэл мэдээллээр эмэгтэй нэр дэвшигчдийг дүрсэлдэг дараагийн нэг загвар нь тэднийг нөлөө бүхий эрчүүдийн дагуул дүрээр гаргах юм. Өндөр албан тушаалтай эмэгтэй хүнийг өөрийн чадлаар гарч ирээгүй, ямар нэг нам хүчин, нөлөө бүхий хүний туслалцаатайгаар тодорсон гэх хандлага байдгийг “Глоб Интернэшнл Төв” ТББ-аас эмэгтэй улстөрчдийн талаар хийсэн Хэвлэл мэдээллийн мониторингийн тайланд дүгнэжээ. Иймд, эмэгтэй нэр дэвшигчийг нөлөө бүхий эрэгтэй хүнд хамааруулж гаргахгүй байхыг анхаараарай.



# 5.

## **Гадаад үзэмж, хувцаслалтаар сонжих, ялгаварлан гадуурхахгүй байх:**

Нас, биеийн галбир, төрх, хувцаслалт, нүүр будалт, биеэ авч явах байдал зэрэг эрэгтэй нэр дэвшигчийн талаар дурддаггүй зүйлсийг эмэгтэй нэр дэвшигчийг дүрслэхдээ бүр тоочдог. Эрэгтэй хүнийг боловсрол, ажил мэргэжлийн туршлага, алдаа оноогоор нь дүрсэлдэг атлаа эмэгтэй хүнийг царай зүс, бие галбир, өмссөн зүүснээр нь сонжиж буй нь хүйсээр ялгаварлаж буй хэрэг гэдгийг сайтар ойлгоорой.



# 6.

## **Хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой асуудлыг зөвхөн эмэгтэй гишүүд, улстөрчдөд хамааруулахаас зайлсхийх:**

Хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой нийгмийн асуудал гарах бүрд УИХ-ын эмэгтэй гишүүд ажлаа хийхгүй байна гэж шүүмжлэх нь элбэг. Энэ нь хүйсээр илт ялгаварласан хэрэг болохыг сайтар ойлгоорой. Иймд УИХ-ын эмэгтэй гишүүдийг шүүмжлээд өнгөрөх бус, асуудлыг бий болгоод байгаа системийн алдааг эрж олж, түүнийг засаж залруулах зохих байгууллагууд, албан тушаалтнуудаас хариуцлага нэхэх нь мэргэжлийн сэтгүүлчдийн жинхэнэ ажил. “Хавсралт - 9”-өөс энэ талаар гүнзгийрүүлэн уншина уу.



# Эмэгтэй нэр дэвшигчийн зураг, дүрсийг авахдаа гаргадаг түгээмэл алдаанаас зайлсхийх нь

Сэтгүүл зүйн бүтээлд ашиглаж байгаа зураг, дүрс ч мөн эмэгтэйчүүдийг хэвшмэл ойлголтын дагуу гаргах нь түгээмэл байдаг. Тухайлбал:

## ⊗ Түгээмэл алдаа

Эмэгтэйчүүдийг албан бус зургаар, ингэхдээ гол төлөв энгийн иргэн, ээж, гэргий, мэргэжилтний хувиар дүрслэх.

Эрэгтэй нэр дэвшигчийг инээмсэглэсэн, нүдэнд дулаахан байдлаар, эмэгтэй нэр дэвшигчийг хүйтэн, догшин харцтайгаар гаргах.

Өдөр тутмын сонин, мэдээллийн сайтуудын улс төрийн буланд эмэгтэй нэр дэвшигчдийн зураг цөөн байх.

Эмэгтэй нэр дэвшигчтэй ярилцлага хийхдээ гэрт нь очиж, нөхөртөө цай аягалж өгч байгаа, хүүхдүүдээ асарч байгаа зэргээр дүрслэн гаргах.

График, өгөгдлийн дүрслэл ашиглахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хэвшмэл/уламжлалт дүрд тоглуулсан зураг, дүрслэл ашиглах.

## ☑ Үүнээс хэрхэн зайлсхийх вэ?

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүйсээс нь хамааран ялгавартай дүрслэхээс зайлсхийж, хүйсээс үл шалтгаалан нэр дэвшигчдийг ажил хэрэгч байдлаар дүрслэх.



Ямар ч хүн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарахдаа аятайхан харагдахыг хүсдэг. Иймд, эмэгтэй нэр дэвшигчээс яриа авахдаа гадаад төрхдөө анхаарах цагийг тэдэнд гаргаж өгөөрэй. Телевизийн студид нүүр будалтын артист байгааг дуулгаж, өөртөө итгэлтэй харагдахад нь туслах боломжтой. Хэрэв үйл явдлын үеэр фото зураг авах бол гэрэл зурагчиндаа урьдчилан сануулж, зөвлөлдөх нь зүйтэй.

Энэ алдааг гаргахгүйн тулд эмэгтэй нэр дэвшигчийн зургийг мэдрэмжтэй авч гаргах нь чухал. Эмэгтэй нэр дэвшигчийн хөрөг зургийг хэрхэн мэдрэмжтэй, чанартай авах тухай Марейке Гюньше багш зөвлөгөө өгснийг [“Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь”](#) редакцуудад зориулсан удирдамжаас авах боломжтой.

Энэ нь жендэрийн хэвшмэл ойлголтыг дэвэргэсэн хэрэг гэдгийг ойлгож, эмэгтэй нэр дэвшигчийг эзэмшсэн мэргэжил, ажлаа хийж буйгаар дүрслэн харуулах.

График, өгөгдлийн дүрслэлд хэвшмэл өнгө, дүрслэл ашиглахаас зайлсхийх. Тухайлбал, эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн илэрхийллийг ягаан өнгө, эрэгтэйчүүдтэй холбоотойг цэнхэр өнгөөр тодорхойлох нь зохимжгүй гэдгийг гэрэл зурагчин, график дизайнер зэрэг редакцын бусад гишүүдэд хэлж сануулах хэрэгтэй.

# Жишээ



Icons illustrating gender stereotypes:

- Icon of a woman cooking (marked with a red X)
- Icon of a man in a hard hat (marked with a red X)
- Icon of a woman and a man (marked with a red X)
- Icon of a butterfly (marked with a red X)
- Icon of a soccer ball (marked with a red X)

*feminine*

**masculine**

# Хүйс үл хамааран нэр дэвшигчдийг хэрхэн мэдрэмжтэй гаргах вэ?

Сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн талаарх сөрөг, ташаа мэдээлэл, гүтгэлэг, доромжлол эрс нэмэгддэг. Нэн ялангуяа цахим орчны дайралт, үзэн ядалт, доромжлолд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн аль аль нь өртдөг ба үүнд жендэрийн хэвшмэл ойлголт ихээхэн нөлөөлдөг. Тухайлбал, эр хүний бахархал, эрэгтэй хүн ийм байх ёстой гэх хэвшмэл ойлголт нийгэмд хүчтэй байдгаас үүдэн эрэгтэйчүүдийг үзэл бодлоо илэрхийлэх, санал хэлэх, тайлбар тавихад “хүүхэн шиг шалчиганаад, гоншигнолоо, айлын авгай нарын сэдэв ярилаа” гэх мэт шүүмжлэл олон нийтээс ирэх нь элбэг. Эмэгтэйчүүдийн хувьд мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагаас илүү гадаад төрх байдал, хувцаслалт, хувийн амьдрал, гэрлэлт зэрэг хүйсийн онцлогт нь анхаарал хандуулах нь бий. Иймд сэтгүүлчид сонгуулийн үеэр бүтээл гаргахдаа мэргэжлийн болон ёс зүйн дүрмээ баримтлахын сацуу нэр дэвшигчдэд хүйсээс үл хамааран тэгш хандах, мэдрэмжтэй дүрслэх нь юу юунаас илүү чухал юм.

## ⊗ Болохгүй

Хүйсэд тулгуурлан нэр дэвшигчдэд ялгавартай хандах, дүрслэх. Тухайлбал, эмэгтэй нэр дэвшигчийг хэн нэгний эхнэр, охин, найз бүсгүй гэж дүрслэх замаар эрэгтэй хүнтэй хамаатуулах, амжилтад хүрэхдээ тэдний дэмжлэгийг авсан мэт ойлголт төрүүлэх.

Бүтээлийн сэдэв, агуулга, эх сурвалжид аль нэг хүйс давамгайлах.

Нэр дэвшигчийн гэр бүлийн байдал, нас зэргийг тодотгох.

Жендэрийн хэвшмэл ойлголт бүхий зураг, дүрслэл, үг хэллэг ашиглах. Жишээ нь, эрэгтэй нэр дэвшигчийн гадаад үзэмжид анхаарал хандуулаагүй хэр нь эмэгтэй нэр дэвшигчийн бие галбир, хувцаслалт, нүүр будалт, биеэ авч явах байдлыг онцлох.

## ✔ Болно

Эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдэд ижил ач холбогдол өгч, төлөөллийн дуу хоолойг тэгш хүргэх. Жишээ нь, нэвтрүүлэгт урих зочдын тоог хүйсийн хувьд тэнцвэртэй байлгах.

Тухайн хүний амжилт, зорилго, нөхцөл байдлыг тайлбарлахдаа хүйсийг тодотгохгүй байх.

Нэр дэвшигчдийн гэр бүлийн байдал, нас зэргийг нэр дэвшигч өөрөө хүссэн, нэн шаардлагатай биш л бол дурдахгүй байх.

Зураг, дүрслэл, ашиглах үг хэллэгтээ жендэрийн мэдрэмжтэй хандах. Эмэгтэй нэр дэвшигчийг дүрслэн бичих, фото зураг авах, асуулт тавихдаа энэ хүн эрэгтэй байсан бол ижил хандах байсан эсэхээ эргэцүүлэх.



# Эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголтыг эвдэхэд туслах арга замууд

**ӨӨРСДӨӨР НЬ ЯРИУЛАХ.**  
Эмэгтэйчүүдийг яриулж байж асуудлыг олон талаас гаргаж ирнэ.

**БАЙДЛЫГ ЭРГҮҮЛЖ ТАВИХ.**  
“Хэрвээ энэ нэр дэвшигч эрэгтэй байсан бол би гэр бүлийн байдал, биеэ авч явах байдал, хувцаслалт зэргийг нь тодотгох байсан уу?” гэдгийг бодолцох нь зүйтэй. Тухайлбал, эмэгтэй нэр дэвшигч өөрөө эх хүн гэдгээ ярьж эхлээгүй л бол сэтгүүлч асуух шаардлагагүй юм.

**ТЭДНИЙГ УЛС ТӨРИЙН БАЙР СУУРЬ, ҮЗЭЛ САНАА, ХИЙЖ БУЙ АЖЛААР НЬ ДҮРСЛЭХ.**

Эмэгтэй нэр дэвшигчдийг хэвшмэл ойлголтын дагуу дүрсэлдэг сэтгүүл зүйн практикийг өөрчлөхийн тулд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг улс төрийн байр суурь, үзэл санаа, хийж байгаа ажлаар нь дүрслэх чухал. Үүнд, улс төрийн аливаа асуудлаар эмэгтэйчүүдийн санал бодлыг гаргах, мөн сонгуулийн үеэр эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдэд асуултад хариулах, байр сууриа илэрхийлэх адил тэгш боломж өгөх шаардлагатай. Ардчилсан нийгмийн бусад нийгмээс ялгарах гол онцлог бол цөөнхийг хүндэтгэх явдал гэдэг. Эмэгтэй нэр дэвшигчид цөөнх гэдэг утгаар тэдний үзэл санааг тусгах нь чухал билээ.







## БҮТЭЭЛ БЭЛЭН БОЛСНЫ ДАРАА

### Редакц, сэтгүүлч, юу хийх ёстой вэ?

Ийнхүү та бэлэн болсон бүтээлээ нийтлэхээс өмнө эцсийн удаа нягтлах, үзэгч, уншигчдад хүртээмжтэй хүргэхийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлээрэй. Мөн Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг давхар уншихыг зөвлөж байна. ("Хавсралт - 10"-аас үзээрэй).

Бүтээлээ редакторлах явцдаа дараах хяналтын хуудсыг ашиглан нягт нямбай, олон талын эх сурвалжтай, даацтай болсон эсэхийг шалгаарай.

Хавсралт 10

хуудас 60

### Жендэрийн сэдвээр бичих сэтгүүлч, редакторын хяналтын хуудас

#### Өнцөг:

- Жендэрийн мэдрэмжтэй байдлаар өнцгөө тодорхойлсон уу?
- Гарчиг, лийд сонирхолтой байна уу?
- Жендэрийн хэвшмэл ойлголтоос зайлсхийж, эсвэл халж чадсан уу?

#### Эх сурвалж:

- Баримт бичиг, судалгааны эх сурвалжаас гадна аман эх сурвалж, ярилцлагыг зохистой ашигласан уу?
- Гурван түвшний аман эх сурвалжийн ярианаас эш татсан уу?
- Эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэх тал дээр хангалттай хүчин чармайлт гаргасан уу?

#### Үг хэллэг, найруулга:

- Ялгаварлан гадуурхсан, сексист, үзэн ядах үг хэллэгээс татгалзсан уу?
- Энгийн иргэдэд ойлгомжтой үг хэллэг, нэр томъёо ашигласан уу?

#### Зураг дүрслэл:

- Хувь хүний зураг, дүрсийг өөрийнх нь зөвшөөрөлтэйгөөр нийтэлсэн үү?
- Нийгмийн болон хүйсийн төлөөллийг тэнцвэртэй дүрсэлсэн үү?
- Аль нэг хүйсийг аливаа өнгө, үсгийн фонт, эсвэл амьтан, бэлгэ тэмдгээр төлөөлүүлээгүй гэдгээ нягтлах.

#### Судалгаа:

- Хангалттай суурь мэдээлэл, дүн шинжилгээ агуулсан уу?
- Шинэ дата, судалгаа багтаасан уу?

Жич: Эмэгтэй нэр дэвшигчийн хөрөг зургийг хэрхэн мэдрэмжтэй, чанартай авах тухай Марейке Гюньшегийн өгсөн зөвлөгөөг ["Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь"](#) редакцуудад зориулсан удирдамжаас дэлгэрүүлэн унших боломжтой.

Жендэрийн тэгш бус байдал нь чухал сэдэв гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ сэдвээр хийсэн **нийтлэл, нэвтрүүлгээ аль болох оргил цаг/эхний нүүр зэрэгт онцгойлон гаргахад анхаараарай**. Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвээр бүтээл хийхэд зураг, дүрслэлийн олдоц муу байдаг. Энэхүү бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд "Мэдрэмжтэй мэдээлье" нэгдлээс гэрэл зураг болон инфографикийн нээлттэй мэдээллийн сан үүсгэснийг ашиглах боломжтой.

# 3.

## СОНГУУЛИЙН ДАРАА

- Сонгуулийн үр дүнг жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх нь
- Сонгогчийн боловсрол, жендэрийн мэдрэмжийг сайжруулах нь

# СОНГУУЛИЙН ҮР ДҮНГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ МЭДЭЭЛЭХ НЬ

**С**онгуулийн үр дүнг мэдээлэхдээ сэтгүүлч, редакторууд иргэдийн хувьд юу хамгийн чухал, ач холбогдолтой болохыг дахин эргэцүүлээрэй. Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн албан ёсны үр дүнг мэдээлэх нь зүйн хэрэг ч үүнд хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй хандаж, сонгуулийн үр дүнд төлөөлөл хэрхэн хангагдсаныг анализ, дүн шинжилгээгээр гаргаж тавих нь илүү чухал юм. Ингэхдээ дараах үндсэн зарчмуудыг баримтлахаа бүү мартаарай.

- **Баримтад тулгаарлах:**

Батлагдаагүй мэдээллийг цацахгүй байх, мэдээллийг дахин нягтлах, аль нэг нам, нэр дэвшигчийг дэмжсэн баримтыг сонгож гаргахгүй байх.

- **Төвийг сахих:**

Үйл явцыг хөндлөнгөөс мэдээлэхийн тулд хувийн үзэл бодол, сэтгэл хөдлөлөө дарж, намын бус байр сууринаас хандах шаардлагатай.

- **Тэнцвэрт байдлыг хангах:**

Танай редакц аль ч улс төрийн нам, эсвэл, нэр дэвшигч, иргэдэд нээлттэй байж, нийгмийн олон янзын төлөөллийн дуу хоолойг хүргэхэд гол анхаарлаа хандуулаарай.

### **Шударга байх:**

- Бүх нэр дэвшигчдэд тэгш, шударга хандаж, бусдын дайралт, шүүмжлэлд өртсөн хэнд ч тайлбар өгөх боломжийг олгох нь зүйтэй. Гэхдээ тэдэнд зөвхөн ярих боломжийг олгох бус иргэдийн өмнөөс нухацтай асуулт тавьж, нөхцөл байдлыг тодорхой болгох хэрэгтэй.

# Сонгуулийн үр дүнг хэрхэн тоймлох вэ?

**Х**эвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн үр дүнг мэдээлэхдээ ашиглаж болох хэд хэдэн санааг онцолж байна.

## ҮР ДҮНД АНАЛИЗ ХИЙХ:


Юун түрүүнд хүйсээр ангилсан өгөгдлийг ашиглахыг зөвлөж байна. Жишээ нь, УИХ-ын сонгуульд оролцсон улс төрийн нам, эвслийн авсан суудлын тоо, шинээр бүрдсэн парламентын хүйсийн харьцааг харуулж болно. Мөн хүйсээс гадна залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бусад төлөөлөл хэр хангагдсаныг давхар шинжилж болох юм.

## СОНГУУЛИЙН ҮР ДҮНГ БҮС НУТАГ, ОЛОН УЛСТАЙ ХАРЬЦУУЛАХ:

Олон улсын парламентын холбоо, дэлхий дахин болон бүс нутгийн бусад улс орнуудын сонгуулийн үр дүнгийн статистиктай харьцуулан анализ боломжтой.

## СОНГОГЧИЙН ИРЦЭД АНАЛИЗ ХИЙХ:

Тоон мэдээлэлд тулгуурлан сонгогчдын хүйсийн харьцаа, идэвх оролцоог шинжлэх боломжтой. 2021 оны Монгол



Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар Сонгуулийн ерөнхий хороо, ЛИЙД төгсөгчдийн холбоо ТББ-тай хамтран анх удаа сонгуулийн ирцийг 12 насны ангилал, дүүрэг, аймаг, сум, гадаад улс орон гэсэн газарзүйн байршлаар дэлгэрүүлэн цаг тутам харуулж байсан. 2024 оны УИХ-ын сонгуулиар энэ мэт нарийвчилсан мэдээлэл гарах аваас сэтгүүлчид датанд тулгуурласан анализ хийх боломж бүрдэнэ. Тухайлбал, сонгогчдын оролцоог дан хүйсээс гадна газарзүйн байршил, тойрог, нас зэрэг бусад хүчин зүйлтэй хавсруулан харуулах, өөр хооронд нь харьцуулвал сонирхолтой өнцөг гарах боломжтой.

## СОНГОГДСОН УИХ-ЫН ГИШҮҮДЭД АНАЛИЗ ХИЙХ:

Хууль эрх зүйн орчны өөрчлөлтэй холбоотойгоор 2024 оны Монгол



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ИРЦИЙН МЭДЭЭ



0.03%

563 Ирц бүртгэлд бүртгэгдсэн сонгогчдын тоо

Нийт сонгогчдын тоо 2,040,410

"Тур хэсэг" тэмдэглэгээтэй 50

(Тур хэсэг тэмдэглэгээг сэргээсэн тохиолдолд нийт сонгогчдын тоо нэмэгдэнэ)

09 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22

Цагийн байдлаар



Далгэраггүй мэдээлэл хувирагчээр харих

Гадаадад суугаа сонгогчдын ирц



Улсын УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж, УИХ-ын 78 гишүүнийг тойргоос, 48 гишүүнийг хувь тэнцүүлэх буюу жагсаалтаар сонгохоор болсон. Иймд, сонгогдсон гишүүдийн хүйсийн харьцааг тойрог болон жагсаалтаар ялгах, өмнөх сонгоулиудын үр дүнтэй харьцуулах, эмэгтэй төлөөллийн тоонд хэрхэн нөлөөлснийг хэмжих боломжтой.

### ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТЭД ТУЛГУУРЛАН АНАЛИЗ ХИЙХ:

Дээрх тоон үзүүлэлтүүдээс гадна их сургуулийн багш, судлаачид,

энэ чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг бие даасан, хараат бус шинжээчдийг урьж сонгуулийн үр дүнг тоймлох боломжтой. Түүнчлэн сонгуулийн үр дүнгийн талаар сөрөг хүчин, олон нийт, сонгогчдын байр суурийг хүргэхээ бүү мартаарай.

Хэвлэл мэдээлэл байгууллагуудын ач холбогдол өгдөг УИХ-ын гишүүдийн тангараг өргөх ёслол, чуулганы нээлтийг сурвалжлахдаа сонгогдсон төлөөллийн гарал угсаа, хувцаслалт, гадаад үзэмжийг онцгойлж харуулахгүй байх нь зүйтэй.

# Сонгогчийн боловсрол, жендэрийн мэдрэмжийг сайжруулах нь


Хэвлэл мэдээллийн туйлын зорилго бол улстөрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын үзэл бодол, байр суурийг хүргэх, тэдний дуу хоолой болох бус улс төрийн бодлого, шийдвэр энгийн иргэдэд хэрхэн нөлөөлж буйг ойлгуулах юм. Хэвлэл мэдээлэл энэ үүргээ биелүүлж үзэгч, уншигч, сонсогчдодоо үнэн зөв, тэнцвэртэй мэдээллийг өгч чадвал өөрсдийг нь хамгийн сайнаар төлөөлөх хүнээ сонгож, бодлого, үйл ажиллагаанд нь хяналт тавих боломжийг иргэдэд олгож байна гэсэн үг. Иймд ардчиллыг бэхжүүлж, сонгогчдыг мэдээлэлтэй сонголт хийхэд хөтөч болох эрхэм үүргийг хүлээж буй сэтгүүлч, редакторууд сонгуулийн өмнө бэлтгэлээ базаах, сонгуулийн үеэр олон талт бүлгүүдийн дуу хоолойг нийгэмд тэнцвэртэй, мэдрэмжтэй гаргахад тань энэхүү удирдамж тус болно гэдэгт итгэлтэй байна. Харин одоо энэ боломжийг уншигч, үзэгч, сонсогчдодоо бүрдүүлж өгөх нь та бидний дараагийн чухал зорилт бөгөөд энэ нь сонгуулийн хэсэгхэн хугацаанд бус тасралтгүй үргэлжлэх үйл явц гэдгийг эцэст нь сануулъя. Тиймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн

бус үед ч сонгогчдын боловсролд анхаарал хандуулж, дараах санаачилгуудыг үйл ажиллагаандаа тусгахыг зөвлөж байна. Үүнд:

Хэвлэл мэдээллийн салбарынхны өмнө нь хэрэгжүүлсэн “Надад нэг санал байна”, “Өглөө” зэрэг сонгогчдын боловсрол, идэвх, оролцоог сайжруулахад чиглэсэн төслүүдийг судлаарай.

Редакцын хамт олонтойгоо сонгогчдын боловсрол, жендэрийн мэдрэмжтэй байдлыг сайжруулахын тулд юу хийж болох талаар брэйнсторминг хийж болно. Энэ үеэр гарсан шинэ санал, санаачилгуудыг үйл ажиллагаандаа тусгах боломжтой.

Хамтран ажиллах түншээ сонгоорой. Сонгогчдын боловсрол төвөөс эхлээд сонгогчдын боловсрол болон жендэрийн чиглэлээр идэвхтэй ажилладаг дотоодын болон олон улсын байгууллагуудын жагсаалт гаргаж болно. Тэр жагсаалтынхаа дагуу



хамтран ажиллах санал тавьж, түншлэл бий болгоорой. Бусад хэвлэл мэдээллийн байгууллагатай ч хамтарч ажиллаж болох бөгөөд ингэснээр үйл ажиллагааныхаа цар хүрээ, үр нөлөөг илүү сайжруулах боломжтой.

Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв нь сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа, явцын талаар сонгогчдод тогтмол мэдээлэл өгөх, сонгогчдын сонгуульд идэвхитэй оролцуулахад чиглэсэн олон талт ажиллагааг нээлттэй зохион байгуулдаг.

Иймд, сонгуулийн болон сонгуулийн бус үеэр Мэдээлэл, судалгаа, сургалтын төвтэй хамтран ажиллах, мэдээллийн албан ёсны эх сурвалж болгох боломжтой.

Түүнчлэн СЕХ сэтгүүлчдыг тогтмол мэдээллээр хангах зорилгоор “Сонгуулийн боловсрол клуб” ажиллуулдаг ба сард 1-2 удаа уулзалт, сургалт зохион байгуулж сэтгүүлчдийн

авахыг, мэдэхийг хүссэн чиглэлээр мэдээлэл бэлтгэж өгдгийг энд дурдъя.

Контентын төлөвлөгөө гаргахдаа энэхүү гарын авлагад багтаасан зөвлөмжүүдийг дагаж мөрдөөрэй. Мөн ямар сувгаар дамжуулан хэнд хүргэхээ сайтар тооцоолж байж контентын агуулга, хэлбэрээ тодорхойлох нь зүйтэй. Тухайлбал, сонгуулийн насны дийлэнхийг бүрдүүлж байгаа хэрнээ идэвх, оролцоо харьцангуй султай байдаг залуус руу чиглэсэн кампанит ажил өрнүүлэх зорилготой бол аль болох бага тексттэй, мультимедиа хэлбэрийн бүтээлүүд байж болох юм.

**ХАВСРАЛТ**



# ХАВСРАЛТ 1.

## 2024 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮЕЭР СЭТГҮҮЛЧДИЙН МЭДВЭЛ ЗОХИХ ЧУХАЛ ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ ЦАГЛАВАР



**2024.03.01**

Үндэсний аудитын газар УИХ-ын сонгуулийн зардлын дээд хэмжээг СЕХ-гоор батлуулж, нийтэд ил тод болгоно.



**2024.04.29**

2024.04.29-өөс өмнө: Сонгуульд оролцох нам, эвсэл хүсэлтээ СЕХ-нд ирүүлнэ.



**2024.05.14-20**

Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа явагдана.

СЕХ жагсаалт болон тойрогт өрсөлдөх нэр дэвшигчдийг олон нийтэд зарлаж, үнэмлэх гардуулна. Мөн эл өдрөөс эхлэн Авлигатай тэмцэх газар нэр дэвшигчээр бүртгэгдсэн нийт нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг нээлттэй байршуулна.

**2024.06.10**

2024.6.03-наас өмнө: Харилцаа холбооны зохицуулах хороо сурталчилгааны болон мэтгэлцээний төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийг батална.

**2024.6.03**

2024.5.23- ны дотор: Нэр дэвшигчид хөрөнгө орлогын мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ.

**2024.5.23**

**2024.6.10-2024.8.12**

Төрийн аудитын дээд байгууллага Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлангийн талаарх дүгнэлтийг цахим хуудастаа нээлттэй байршуулна.

**2024.06.20-23**

Нийт дөрвөн өдөр гадаадад байгаа иргэдээс тухайн улсын орон нутгийн цагаар 07:00-22:00 цагийн хооронд санал авна.



**2024.06.26**

Нэр дэвшигчдэд үнэмлэх гардуулсан өдрөөс сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлж зургаадугаар сарын 26-ыг дуустал үргэлжилнэ. Нэр дэвшигчид нийт 17 хоног сурталчилгаа явуулна.



**2024.6.28**

Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.



**2024.7.13**

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг өргөн мэдүүлнэ.

## ХАВСРАЛТ 2.

### Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг сурвалжлах нь

**Х**үнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд заасан нь жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчны үндэс суурь болдог. Түүнчлэн манай улс 1946 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1954 оны Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц, 1981 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид нэгдэж, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн эрхийг хамгаалах амлалт өгсөн. Энэ бүх үүрэг амлалтыг биелүүлэхэд хэвлэл мэдээллийн салбар нэн чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, жендэрийн тэгш байдал, тэгш эрхийн талаарх мэдээ, сурвалжилга нь хэвлэл мэдээллийн гүйцэтгэдэг нийгмийн “хоточ нохой”-н үүргийн салшгүй, чухал хэсэг юм. Энэ үүргээ гүйцэтгэж чадахгүй бол нэг л мэдэхэд 2030 он болчихсон, бид тогтвортой хөгжлийн зорилтоо биелүүлээгүй сууж байна. Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд Монгол Улс 2015 он гэхэд УИХ дахь эмэгтэйчүүдийн суудлыг 30 хувьд хүргэнэ гэсэн амлалт өгсөн боловч 2012 оны сонгуулиар УИХ дахь эмэгтэйчүүдийн тоо өсөөд, өсөөд амлалтынхаа талд нь ч хүрээгүй гашуун

туршлага бий. Энэ бүхнийг өөрчлөх эхлэлийг чухам хэвлэл мэдээлэл л тавьж чадна.

■ Учир нь, аженда-сеттингийн онолоор хэвлэл мэдээлэл нь олон нийтийн анхаарлаа хандуулах үйл явдал, асуудлуудыг сонгож танилцуулдаг гэж үздэг. Жишээ нь, өнөөдөр Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс аль нь “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо” сэдвийг чухалчлан үздэг вэ? Улс төрийн аливаа мэдээний агуулгад энэ асуудал ямар нэг байдлаар тусдаг уу? Эсвэл тусгай булан байдаг уу? Яг энэ асуудлыг хэлэлцэх сэдэв болгосон уу гэх мэтээр асуудлыг нарийвчлан хэмжиж, энэ сэдэв нь тухайн хэвлэл мэдээллийн аженда байж чадаж байгаа эсэхийг тодорхойлж болно.

■ Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь хүний үндсэн эрхийг хангах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, хөгжлийн зөв бодлогод нөлөөлөх зэрэг олон асуудлыг хамарсан чухал сэдэв боловч олон улсын хэмжээнд болон Монголд энэ сэдвийг хэвлэл мэдээлэл барьж авч сурвалжлахдаа хойрго байна.

■ Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны үр дүнг харахад нийт мэдээллийн ердөө зургаан хувь нь жендэрийн тэгш/тэгш



бус байдлын талаар дурджээ. Тэгвэл Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд сэтгүүл зүйн бүтээлийн агуулгад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд өдөр тутмын сонин, сайтуудын улс төрийн мэдээллийн нийт агуулгын ердөө 1.8 хувьд л жендэрийн тэгш/тэгш бус байдлын талаар дурдсан байв. Энэ нь зөвхөн тодорхой түлхүүр үгээр хайлт хийхэд гарч ирсэн ололт бөгөөд жендэрийн тэгш бус байдлын сэдвийг чухалчлан бүтээл гаргасан кэйс байгаагүй юм. Олон улсын хэмжээнд ч ижил дүр зураг ажиглагддаг. Тухайлбал, судлаач Люба Кассовагийн 2022 онд хэвлүүлсэн тайлангаас үзэхэд 2017 оноос хойш гарсан мэдээний агуулгын ердөө 0.02 хувь нь жендэрийн тэгш бус байдлын сэдвийг онцолсон байжээ.

■ Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо сэдвийг олон улсын хэмжээнд хангалттай мэдээлж, сурвалжлахгүй байгаа ч сэдвийн ач холбогдол, орон зайг олж харсан санаачилгууд өрнөж байгаа юм. Жишээ нь, АНУ-ын нэр хүндтэй “Texas Tribune” хэвлэл мэдээллийн байгууллагын ерөнхий эрхлэгч Эмили Рамшоу, олон нийтийн эрхлэгч Аманда Замора нар 2020 онд “The 19th\*” нэртэй бие даасан, ашгийн бус редакц үүсгэн байгуулсан. Энэ нь улс төр, жендэрийн асуудлыг хэвлэл мэдээлэл хэрхэн мэдээлж, сурвалжилдаг арга замыг

өөрчлөх зорилготой бөгөөд АНУ-ын эмэгтэйчүүдэд сонгох, сонгогдох эрхийг олгосон Үндсэн хуулийн 19-дэх нэмэлт, өөрчлөлтөөс санаа авч нэрээ өгчээ. Мөн нэрний баруун дээд буланд алтан гадас одон байрлуулж өгсөн нь ардчиллаас гээгдсэн хүмүүс байгааг сануулах, тэдний дуу хоолой болж ажиллахыг илтгэж байгаа аж.

■ Монгол Улсын хувьд mpress.mn, reak.mn мэдээллийн сайт, “Зууны мэдээ” сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлыг онцгойлон авч үзэх тухай редакцын бодлогодоо тусгаж, энэ сэдвээр тусгай булан, цуврал бүтээл зэргийг хийж ирсэн сайн туршлага бий.

■ Харин одоо улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдал яагаад мэдээний үнэ цэн бүхий чухал сэдэв болохыг харцгаая.



## ХАВСРАЛТ 3.

### Эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрх

Э

ртний Грек болон Ром, түүнчлэн XVIII зууны сүүлчээр Европт бий болсон ардчилсан цөөн оронд улс

төр гэдэг эрэгтэйчүүдийн дархлагдсан ажил байв.

Эмэгтэйчүүдийн сонгох эрхийн төлөөх тэмцэл XIX зуунаас, ялангуяа Их Британи, АНУ-д эрчимтэй өрнөж эхэлсэн ч эдгээр нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хуульчилсан анхдагч улс болж чадаагүй билээ. Тодруулбал, 1893 онд Шинэ Зеланд, 1902 онд Австрали, 1906 онд Финланд, 1913 онд Норвегийн эмэгтэйчүүд үндэсний сонгуульд оролцох эрхээ баталгаажуулсан байдаг.

Дэлхийн I дайн ба түүний үр дагавар эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хангах ажлыг хурдасгасан түүхтэй. 1914-1939 онд ЗХУ, АНУ, Их Британи зэрэг 28 улс орны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил тэгш эрх эдэлж, сонгуульд санал өгөх боломжтой болжээ. Мөн Дэлхийн II дайны дараа тусгаар тогтнолоо баталгаажуулсан бараг бүх улс орон эрэгтэйчүүд,

эмэгтэйчүүдийн улс төрийн эрх тэгш байдлыг хуульчилсан бөгөөд XX зуунд эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийн төлөөх хөдөлгөөний хувьд түүхэн ахиц дэвшил гарсан билээ.

Монголчуудын хувьд 1924 онд анхдугаар үндсэн хуулиа батлахдаа “Улсын их, бага хурал ба нутгийн хурлуудад төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхийг эдэлбэл зохих тус улсын харьяат эр, эм ялгаваргүй хэн боловч эдлэх” тухай зааж эмэгтэй, эрэгтэй хүний улс төрийн тэгш эрхийг хуульчлан тунхагласан Азийн анхны улс болсон. Үүнийгээ бид ардчилалд шилжихдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11-т улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй хэмээн зааж дахин баталгаажуулсан билээ. Харамсалтай нь, хүн амын тэн хагасаас илүүг бүрдүүлж буй эмэгтэйчүүд хуульд заасан сонгох, сонгогдох эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй өдийг хүрснийг олон тоо баримт харуулдаг.

# ХАВСРАЛТ 4.

## Хууль эрх зүйн шинэчлэл

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

2023 оны тавдугаар сарын 31-нд Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” хэмээн өөрчлөн найруулсан. Олон улсын туршлагаас үзэхэд пропорционал тогтолцоо буюу хувь тэнцүүлэн төлөөлөх арга нь хүйсийн тэгш байдлыг хангахад илүү үр нөлөөтэй байдаг аж. Тиймээс энэхүү өөрчлөлт эмэгтэйчүүд төдийгүй залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг улс төрийн шийдвэр гаргах түвшинд дутагдаж байгаа нийгмийн бүлгийн төлөөллийг хангахад хувь нэмэр оруулна хэмээн судлаачид үзэж буй. Учир нь, 2012 оны сонгуулиар холимог тогтолцоог анх удаа ашиглахад УИХ дахь эмэгтэйчүүд төдийгүй олон намын төлөөлөл, бие даан нэр дэвшигчид өмнө нь байгаагүйгээр нэмэгдсэн туршлага бий. Гэвч 2016 онд сонгууль болохоос хоёр сарын өмнө тогтолцоог өөрчилж, томсгосон мажоритар хэлбэрийг сонгож байв. Ташрамд сонирхуулахад, өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд найман удаа УИХ-ын сонгууль болоход зургаа удаа сонгуулийн тогтолцоог өөрчилсөн байдаг. Иймд, үүнийг Үндсэн хуульдаа тусгаж өгснөөр хууль тогтоогчид өөрсдөдөө давуу тал бий болгох зорилгоор сонгуулийн тогтолцоог байнга сольдог туршлагад цэг тавьж байгаа юм.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

2023 оны зургаадугаар сарын 16-нд УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа хүйсийн квотыг 2024 оноос 30 хувь, 2028 оноос 40 хувьд хүргэхээр болсон юм. Үүний зэрэгцээ нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглож, 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг хуульчилснаар эмэгтэйчүүдэд ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлсэн билээ. Эдгээрийг зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг Сонгуулийн төв байгууллага бүртгэж авахгүй гэж заасан учраас хуулийн хэрэгжилтийг хүлээх, хянах л үлдэж байна.

## УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ

2023 оны долоодугаар сарын 7-нд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар парламентын тогтолцоог бэхжүүлэх, ардчиллыг хамгаалах чухал институт болох улс төрийн намуудын чиг, үүргийг нарийвчлан тодорхойлж өгсөн. Мөн энэ нь жендэрийн дэвшилт хууль болсныг судлаачид тэмдэглэдэг. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаас жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой чухал заалтуудыг дурдвал:

**8.1.** Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно.

**8.2.** Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана:

**8.2.1.** нууц санал хураалт явуулах;

**8.2.2.** гишүүдийн оролцоо, ил тод байдлыг хангах;

**8.2.3.** нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх.

**8.3.** Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.

**8.9.** Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 8.8-д заасан дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.

**15.2.8.** төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш

байдлыг хангах журам;

**17.7.** Намын төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.

**26.3.1.** төрийн санхүүжилтийн 20-иос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сурган бэлтгэх;

**27.7.** Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улстөрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно.

**20.1.** Намын гишүүн дараах эрхтэй байна:

**20.1.1.** намын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох.



## ЦОНХ: ХҮЙСИЙН КВОТ

**2023** оны байдлаар дэлхийн 137 улсад шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд квот хэрэгжүүлж байна. Хүйсийн квот нь Монголын хувьд цоо шинэ ойлголт биш юм. Тодруулбал, социализмын үед тогтоож өгсөн квотын үр дүнд хууль тогтоох байгууллагын төлөөллийн 23-25 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байсан бол 1990 оноос хойш энэ үзүүлэлт огцом буурсан.

2005 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28.2-т нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй байх заалт байсныг огт хэрэгжүүлэхгүйгээр 2007 онд цуцалсан байдаг. Тэгвэл 2011 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.2-т сонгуульд оролцож байгаа нам, эвслээс нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна гэж зааж өгсөн. Энэхүү шаардлагыг хангаагүй нам, эвслийн нэр дэшигчдийг сонгууль зохион байгуулж байгаа байгууллага бүртгэж авахгүй байхаар хуульчилсан нь уг заалтыг хэрэгжүүлэх хөшүүрэг болжээ. Үүний үр дүнд 2008 онд УИХ-д гурван эмэгтэй гишүүн байсан нь 2012 онд 11, 2016 болон 2020 онд 13 болж нэмэгдсэн ч олон улстай харьцуулахад чамлахаар үзүүлэлт хэвээр байгаа юм. Үүний зэрэгцээ, улс орнуудын сайн туршлагаас үзэхэд хүйсийн квотыг тогтмол нэмэгдүүлж ирсэн боловч Монголд 2011 оноос хойш хөдөлгөөгүй 2023 онтой золгосон. Энэ хугацаанд улс төрийн намууд нэр дэвшигчдийн жагсаалтаа гаргахдаа 20 хувийн квотыг “босго” биш “тааз” мэт ойлгож эхэлснийг судалгаанд дурдсан байв.

2023 оны Сонгуулийн тухай хуулийн шинэчлэлээр хүйсийн квотыг нэмэгдүүлэхэд УИХ дахь эмэгтэй гишүүд, хүний эрхийн тэмцэгчид, Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээний өрнүүлсэн аян, шаардлага хүчтэй нөлөө үзүүлсэн. Түүнчлэн хуулийн хэлэлцүүлгийн үеэр “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн сэтгүүлчид квотын талаар олон нийтэд даацтай мэдээлэл хүргэж байсан нь түүхэнд байгаагүй ахиц дэвшил гарахад нөлөөлснийг тэмдэглэх хэрэгтэй.

## ХАВСРАЛТ 5.

### Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөллийг хангах улс төрийн намын амлалт

*Улаанбаатар хот, 2023 он*

1. Улс төрийн намыг бодлогын институт болгон төлөвшүүлэхэд намын санхүүжилтийг нээлттэй, ил тод болгож, дотоод ардчиллыг бэхжүүлж, хариуцлагын жишгийг тогтоож, жендэрийн тэгш байдлыг дэмжих;
2. Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг дэмжсэн сонгуулийн тогтолцоог сонгож, нэр дэвшигчийн квотыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоо, тэнцвэртэй төлөөллийг хангах;
3. Намын бодлого, дүрэм, журам, хөтөлбөрийг жендэрийн хариуцлагатайгаар шинэчлэн хэрэгжүүлж, ил тод болгох, ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөн намын дотоод ардчиллыг бэхжүүлэх;
4. Намын шийдвэр гаргах бүх түвшинд аль нэг хүйсийн төлөөллийг 40-өөс доошгүй хувьд хүргэх, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хангах;
5. Эмэгтэй гишүүдийн манлайллыг дэмжих хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;
6. Сонгуульд нэр дэвшүүлэх болон төрийн улс төрийн албанд томилохдоо хүйсийн тэгш байдлыг хангах, гарааны тэгш нөхцөлийг бүрдүүлэх санхүүжилтийн арга, механизмуудыг хэрэглэх;
7. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлогоо тодорхойлох, хэрэгжүүлэх;
8. Шийдвэр гаргах түвшинд тэгш төлөөлөлтэй байх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд иргэд, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллахаа амлаж байна.


# ХАВСРАЛТ 6.

## Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг харуулах тоо баримтууд

Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын индекс нь эдийн засгийн оролцоо, боловсрол эзэмших байдал, эрүүл мэнд, улс төрийн эрх мэдэл гэсэн дөрвөн үзүүлэлтээр жендэрийн зөрүүтэй байдлыг 0-1-ийн хооронд хэмждэг бөгөөд 1 гэдэг нь жендэрийн тэгш байдалд бүрэн хүрснийг илэрхийлдэг. Исланд, Норвеги, Финланд,

Шинэ Зеланд, Швед улс жендэрийн эрх тэгш байдлыг хамгийн сайн хангасан учраас жагсаалтыг тэргүүлж байна. Харин Монгол Улс эрүүл мэнд, боловсролоор маш сайн үзүүлэлттэй байгаа ч 146 орноос 80 дугаарт эрэмбэлэгджээ. Энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийн түвшин хангалтгүй, авах ёстой 1 онооноос ердөө 0.099-ийг авч, 121 дүгээрт жагссантай холбоотой юм.

### УИХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ НЭР ДЭВШИГЧИД Хүйсээр, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймаг, нийслэлээр




Эх үүсвэр: Сонгуулийн ерөнхий хороо Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.



УИХ-ЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД БОЛОН СОНГОГДСОН УИХ-ЫН ГИШҮҮД /ХҮЙСЭЭР, СОНГУУЛИЙН ЖИЛЭЭР/

УИХ-ЫН ГИШҮҮД

УИХ-ЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД



2020 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬД ХАМГИЙН ОЛОН ЭМЭГТЭЙГ НЭР ДЭВШҮҮЛСЭН УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЭЛ



Олон улсын парламентын холбооноос сар бүр шинэчлэн гаргадаг Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтаас үзэхэд Монгол Улс 189 орноос 133-дугаарт эрэмбэлэгдэж байна. Монголын парламентын гишүүдийн 17.1

хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа бол Азийн дундаж 21.2 хувь, дэлхийн дундаж 26.5 хувиас дээш байгаа юм. Мөн Засгийн газарт хоёр эмэгтэй (12.5 хувь) сайдтай гэдгээр Монгол Улс дэлхийд 141 дүгээр байрт жагсаж байна.




## ЦОНХ: ОЛОН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХОЛБОО

Төлөөллийн ардчилал, энх тайвныг дэмжих зорилгоор 1889 оны зургаадугаар сарын 30-нд Францын Парис хотод олон улсын парламент хоорондын уулзалтыг анх удаа зохион байгуулснаар Олон улсын парламентын холбоо (ОУПХ) бий болжээ. Энэ өдрийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2018 онд “Олон улсын парламентын өдөр” болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэжээ. Эдүгээ 180 гишүүн, 14 туслах гишүүн орны үндэсний парламентыг нэгтгэсэн тус байгууллага ардчилал, энх тайван, хүний эрх, жендэрийн тэгш байдал, залуучуудын оролцоо, уур амьсгалын өөрчлөлт болон тогтвортой хөгжлийн чиглэлээр парламент хоорондын улс төрийн яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг

өргөжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан ОУПХ-той хамтран парламентын гишүүний хүний эрх, хууль боловсруулах үйл явц, парламентыг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлд 2022-2026 онд Хамтран ажиллах санамж бичигт 2022 оны наймдугаар сарын 15-нд гарын үсэг зурсан байдаг.

Манай улс 1962 онд ОУПХ-ны гишүүнээр элссэн. Парламент дахь оролцоо, төлөөллийг дэмжих нь тус байгууллагын таван стратегийн зорилгын нэг учраас УИХ дахь эмэгтэйчүүд, залуусын оролцоотой холбоотой дата мэдээллийг дэлхийн 193 улстай харьцуулсан байдлаар авч ашиглах боломжтой. Эх сурвалж: <https://www.ipu.org/>

1993 оноос хойш болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн найман удаагийн сонгуульд нийт 22 хүн нэр дэвшсэнээс нэг нь л эмэгтэй байв.



Орон нутгийн эрх барих байгууллагад суудалтай эмэгтэйчүүдийн үзүүлэлт олон улсын хэмжээнд 33.9 хувьтай байгаа бол Монгол Улсад 27.1 хувь байна. Эмэгтэй төлөөлөгчдийн эзлэх хувь НИТХ-д 7.8, аймгуудын ИТХ-д 9.8-24.4 хувь байгаа нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай

хуулийн заалтын хэрэгжилт хангагдахгүй байгааг харуулж байна. Мөн 2021 оны байдлаар улсын хэмжээнд бүх шатны буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нийт 361 даргын 51 (14.1 хувь) нь эмэгтэй байгаа нь аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байх квотыг хангахгүй байв.

## ХАВСРАЛТ 7.

### Эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр редакцуудад хүргэх зөвлөгөө

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хэрэгжүүлж байгаа олон амжилттай туршлагыг судалсны үндсэн дээр редакц эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд төлөвлөж судлах, бүртгэл хөтлөх, редакцын ажилтнуудын оролцоог хангах, эх сурвалжуудаа чадавхжуулах гэсэн дөрвөн стратегийн ангилал гарган хийж болох үйл ажиллагаануудыг “Бодит байдлыг тусга” гарын авлагад зөвлөсөн байдаг. Үүний дагуу редакцуудад өгсөн зөвлөмжийг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс гаргасан “Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь” удирдамжаас авч болно. Харин энд олон улсын болон Монголын сайн туршлага дээр үндэслэн сонгуулийн үеэр эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд ямар стратеги баримталж болох талаар зөвлөмж боловсрууллаа.

#### 1. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Мэдрэмжтэй мэдээлье” жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн чадавх бэхжүүлэх сургалтыг 15 редакцтай хамтран амжилттай зохион байгуулсан. Энэ нь редакцын хамт олныг сэтгүүл зүйн суурь ур чадвараа сайжруулах, хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй болоход туслахаас гадна нэгдсэн ойлголтод хүрэх, нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байв. Тиймээс танай редакц жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн сургалт хийхээр бол Хэвлэл мэдээллийн зөвлөлд хандаж болно. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс редакцын сургалт, уулзалт хийж хамтран ажиллах, эсвэл “Мэдрэмжтэй мэдээлье: Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь” сэдэвт сургагч багш нарт зориулсан гарын авлагыг нөөц хэрэглэгдэхүүний хамт өгч та бүхний чадавх бэхжүүлэх ажлыг дэмжих боломжтой.

#### 2. ГАРААНЫ СУДАЛГАА ХИЙХ

Юуны түрүүнд редакцынхаа одоогийн бэлтгэж байгаа улс төрийн агуулга дахь эх сурвалжуудын хэчнээн хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг тооцоолж гаргаарай. Ингэснээр та бүхний бүтээж буй агуулга хэр жендэрийн тэнцвэртэй (эсвэл тийм биш) байгааг олж мэднэ. Үүнийг хэвлэл мэдээллийн жендэрийн мониторинг хийх туршлагатай судлаачаар хийлгэж

болно. Эсвэл редакцын хамт олноороо 1-7 хоногийн агуулгадаа анализ хийвэл нэгдсэн ойлголттой болоход илүү тустай байдаг. “Мэдрэмжтэй мэдээлье” сургалтын үеэр өдөр тутмын сонин нэг дугаарын улс төрийн мэдээлэлд жендэрийн мэдрэмжтэй байдлын мониторинг хийх дасгал ажилд хагас цаг л зарцуулдаг бөгөөд энэ нь сонирхолтойгоос гадна өмнө нь анзаарч байгаагүй олон зүйлийг мэдэж авахад тустай байдаг.

### 3.ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛОХ

Сонгуулийн үеэр сэтгүүл зүйн бүтээлдээ эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц зорилго тавиарай. Тухайлбал, танай редакцын бэлтгэж буй улс төрийн мэдээний нийт эх сурвалжийн 30 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байвал сонгуулийн үеэр үүнийг 40 хувьд хүргэх зорилго тавьж болно. Хамгийн гол нь хэмжиж болохуйц, дүгнэлт хийж, амжилтад хүрснээ тэмдэглэж болохуйц төлөвлөгөө гаргах шаардлагатай. Мөн эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоо нийтлэлийн бодлого, эсвэл мэдээ, сурвалжилгад тавигдах шаардлагадаа тусгаж өгөх нь зүйтэй. Тухайлбал, BBC стратегийн зорилгодоо үүнийг тусгасан учраас л 50:50 санаачилга төрсөн байдаг. Тэгвэл “Зууны мэдээ” сонин үүнийг дугаарын стандартдаа тусгаж өгснөөр эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах тал дээр байнга анхаарч, үр дүнд хүрсэн туршлага бий.

### 4.ЗОРИЛГОО САНААЧИЛГА БОЛГОН ЗАРЛАХ

Санаачилгадаа тохирсон, гоё нэр өгөх нь редакцын ажилтнууд төдийгүй бусад байгууллага, хамгийн гол нь танай уншигч үзэгчид ойлгож, дэмжихэд тусална. “Bloomberg” “Шинэ дуу хоолой”, BBC 50:50, “France 24” бол “51 хувь” гэх мэт нэрээр санаачилгадаа олны анхаарлыг татаж, уриалга ч гаргаж байсан. Тэгвэл Монголын GoGo.mn мэдээллийн сайт “Тэнцвэр” нэртэй санаачилга гаргаж, зарласан билээ. Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл дутмаг байдаг

учраас сонгуулийн үеэр үүнийг өөрчлөх сайхан санаачилга гаргаж яагаад болохгүй гэж?

### 5.ЭХ СУРВАЛЖИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ

Агуулга дахь жендэрийн тэнцвэрт байдлыг хангахын тулд эх сурвалжуудаа хүйсээр ангилах мониторингийн арга хамгийн бодит үр дүн үзүүлж байгаа. Бүртгэл хөтлөхдөө эх сурвалжийн түвшинг бүү мартаарай. Тухайлбал, улс төрд өнөөгийн нөхцөлд эмэгтэйчүүд цөөн байгаа, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга гэх мэт гол эх сурвалжууд бүгд эрэгтэйчүүд байна. Тиймээс улс төрийн мэдээг илүү тэнцвэртэй байлгахын тулд сонирхлын бүлгийн эх сурвалж эрэгтэй байлаа гэхэд мэргэжлийн бүлгийн байр суурь илэрхийлэх эмэгтэй шинжээчийн яриаг оруулаад ирэхэд л болно. Бүртгэл хөтлөхдөө ашиглаж болох загвар хүснэгтийг Хэвлэл мэдээллийн зөвлөлд хандан авна уу.

### 6.ЭХ СУРВАЛЖИЙН ДАТА САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ

Сэтгүүлчид ашиглахад хялбар болгох үүднээс эмэгтэй эх сурвалжуудтай холбоо барих жагсаалт буюу дата сан гаргаж өгөөрэй. Энэ аргыг BBC, “Bloomberg” зэрэг олон редакц хэрэгжүүлж амжилтад хүрсэн. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс эмэгтэй эх сурвалжийн дата сан үүсгэх хакатон зохион байгуулж, 500 эх сурвалжийн жагсаалт гаргасныг мөн авч болно. Үүнд улс төрийн сэдвээр ярилцлага өгөх боломжтой 100 гаруй эмэгтэй эх сурвалжийн холбоо барих мэдээлэл багтсан байгаа. GoGo.mn мэдээллийн сайтын хамт олон энэхүү дата санг авч, шинэчилсээр 1000 гаруй эх сурвалжийн мэдээлэлтэй болсон байдаг. Ингэснээр эх сурвалж эрж хайх цаг хугацааг хэмнэх, сэтгүүлчдийн ажлыг илүү хялбаршуулах боломжтой.

7.Хамтын ажиллагаа өрнүүлэх

Сонгуулийн үеэр эмэгтэйчүүдийн дуу хоолойг гаргах тал дээр улс төрийн намууд, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Тэдэнд өөрсдийн санаачилга, зорилгоо танилцуулж ойлгуулаарай.



# ЦОНХ: ВВС-ИЙН ТЭГШ БАЙДЛЫН 50:50 ТӨСӨЛ



**BBC** 2016-2020 оны “Олон янз байдал, оролцоог хангах стратеги” гаргахдаа хүний нөөц болон үйл ажиллагаагаа жендэрийн мэдрэмжтэй болгох, бүтээж байгаа агуулгаа төрөлжүүлэх, эх сурвалжид эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээг 50 хувьд хүргэх зорилтуудыг тусгажээ.

BBC-гийн Лондон дахь редакц мэдээн дэх эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэхийн тулд 2017 оноос эх сурвалжийн мониторинг хийж, богино хугацаанд өндөр амжилтад хүрсэн. Тэр цагаас хойш 50:50 төслийн аргачлалыг BBC-гийн 750 гаруй хэлтсээс гадна дэлхийн 30 орны 145 байгууллага ашиглаж байна. BBC одоо энэ аргачлалаа ашиглан үндэстний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлжээ.

2022 оноос Хэвлэл мэдээллийн зөвлөл тустөслийн албан ёсны түнш байгууллага болсон бөгөөд “Мэдрэмжтэй мэдээлэл” редакцын менторшип хөтөлбөрийн хүрээнд “Зууны мэдээ” сонин, GoGo.mn мэдээллийн сайт болон Монголын үндэсний радиогийн хамт олныг 50:50 төслийн албан ёсны түнш болоход зуучилсан билээ.

BBC-ийн 50:50 төслийн гадаад түнш эрхэлсэн ахлах мэргэжилтэн Миранда Холт Вестминстер дэх BBC-ийн улс төрийн шууд хөтөлбөрийн туслах редактораар ажиллаж, сонгуулийн мэтгэлцээний олон хөтөлбөрт продюсер хийж байсан. Тэрбээр 50:50

төслийн үйл ажиллагаанд эхнээс нь оролцож, улс төрийн мэдээллийн шууд нэвтрүүлгүүдэд урих эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх тал дээр идэвх санаачилгатай ажиллаж байсан хүний хувьд өөрийн туршлагаа бидэнтэй хуваалцсан юм.

Засгийн газар, парламентын гишүүд зэрэг улс төрийн нөлөө бүхий хүмүүс ихэвчлэн эрэгтэйчүүд байдаг бөгөөд тэд мэдээг бий болгож, сонирхлын бүлгийн эх сурвалж болдог. Тэгвэл мэдээг илүү тэнцвэртэй болгох үүднээс үйл явдлын сонирхлын бүлгийн эх сурвалж нөлөө бүхий эрэгтэй улстөрч байлаа ч тухайн сэдвийг сайн мэддэг, олон нийтэд хэрэгтэй мэдээлэл өгөхүйц улс төрийн тоймч, судлаач зэрэг өмнө нь телевизээр огт гарч байгаагүй эмэгтэйчүүдийг олж хэлэлцүүлэгтээ оруулж байжээ. Түүнчлэн BBC улс төрийн намуудад хандаж манлайлан гарч ирж байгаа эмэгтэйчүүдийнх нь дуу хоолойг илүүтэй гаргах тал дээр анхаарсан. Мөн эмэгтэй улстөрчдөд зориулсан нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж байжээ.

“50:50 төсөл бүх зүйлийг өөрчлөөд байгаа юм биш. Нийгэм өөрөө өөрчлөгдөж байгаа шүүдээ. Эмэгтэйчүүд илүү өндөр боловсролтой болж байна. Улс төр, бизнесийн шийдвэр гаргах түвшинд манлайлан гарч ирж байгаа эмэгтэйчүүд зөндөө бий. Тэднийг олж, гаргах нь л бидний хийж байгаа ажил” хэмээн Миранда тайлбарласан юм.



# ЦОНХ: “ЗУУНЫ МЭДЭЭ” СОНИН

**BBC** “Зууны мэдээ” сонин “Мэдрэмжтэй мэдээлье” менторшип хөтөлбөрт хамрагдсанаар эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангах тал дээр туштай анхаарч, бодитой үр дүнд хүрсэн. Ингэхдээ дараах үндсэн өөрчлөлтүүдийг хийсэн юм. Үүнд:

- Редакцын бодлого, үйл ажиллагааны стандартаа шинэчлэхдээ эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангах тухай тусгайлан зааж өгсөн.
- Эх сурвалжийн бүртгэл тогтмол хийдэг, өглөөний шуурхай дээр дугаараа ярихдаа бүртгэлийнхээ үр дүнг буюу эх

сурвалжийн олон талт байдал, хүйсийн тэнцвэрт байдлын талаар хэлэлцдэг болсон;

- Эх сурвалжийн дата санг улс төр, эдийн засаг, нийгмийн мэдээллийн албаныхандаа хариуцуулан өгч, тогтмол шинэчлэл хийж хэвшсэн;
- “Амьдралын тойрог”, “Leadership Forum”, “Удмын бахархал” зэрэг онцлох буландаа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг ээлжлэн онцлох жишиг тогтоосон. Жишээ: “Зууны мэдээ” сонины 2023 оны арваннэгдүгээр сарын 27-ны Даваа гарагийн дугаарын нэгдүгээр нүүр.

Иргэдээ өмөөрч бичнэ

# ЗУУНЫ МЭДЭЭ

33 дахь жилдээ

☎ 9758000721320

🌐 zms.mn

☎ 11-321279

📧 zuunimedee

📱 @zuunimedee

✉ zuunimedee@gmail.com

---

ҮНДЭСНИЙ ӨДӨР ТУТМЫН СОНИН
2024 ОНЫ ХОЁРДУГААР САРЫН 26. ДАВАА ГАРАГ. № 37 (7281)
ҮНЭ 2000 ТӨГ

## Амьдралын тойрог

### ШАВЬ НАРТАА ХҮН БАЙХЫГ ЗААДАГ

**Базарбямын НИЯМСҮРЭН**

“Хөдөлмөрийн баатар төрүүлсэн дасгалжуулагч шаггүй хатуу байхдаа” хэмээн таамагласаар бид нийтлэлийн баатраа зорин. Хан-Уул дүүргээс бэлдэж өгсөн бэлтгэлийн даруухан зааландаа бяцхан шавь нараа хүлээж байна гэсээр биднийг угтсан Шархүүгийн Цэвэлмаа хэмээх энэ бүсгүйг Монголчууд сайн танина. Хөдөлмөрийн баатар гавьяат тамирчин М.Уранцэцэг, гавьяат тамирчин Б.Мөнгөнчимэг гээд тив дэлхийд нэрээ дуудуулсан олон шавь нарыг амжит өвд нь хөтөлсөн тэрбээр өөрөө ч дэлхийн энтэй тамирчин. Самбо бөхийн УАШТ-ий найман удаагийн аварга, Дэлхийн аваргаас мөнгө, хүрэл медаль хүртэж “Бөртгэ чоно” наадмын дөрвөн цомын эзэн болж байв.

2014 онд Гавьяат дасгалжуулагч цолоор энгэрээ мялаасан тэрбээр Хан-Уул дүүргийн Спорт хороонд дасгалжуулагч багшаар ажиллаж өсвөрийн жүдочдод их спортын арвин туршлагаа хуваалцаар явна. Шавилхан бистэй, төсөөлж байснаас ч энгийн, шулуухан яриатай гавьяат дасгалжуулагчийн “Амьдралын тойрог”-оор хамтдаа аялцгаа.



### “Бүсчлэлийг бичил бүс, бүлэг суурины тогтолцоогоор хөгжүүлэх нь зөв”

Батчудууны АЛТАНГЭРЭЛ

“Зууны мэдээ” сонин салбар салбарын тэргүүлэгчид, шинийг санаачлагчидыг “Leadership forum” буландаа урьж, Монгол Улсын хөгжлийн гари, боломжийн талаар ярилцаж тэдний сонирхолтой шийдэл, санаануудыг уншигчдадаа хүрдэг билээ. Энэ удаагийн зохиов МУИС-ийн Газарзүйн тэнгисийн доктор, дэд профессор, Монгол Улсын зөвлөх инженер Ц.Базархандыг урилав.

Төгсгөл нь III нүүрт



## Цаг үе

### Дэлхийн Шинэ цогц дэг журам ба Эрвээхэйн хүчин зүйл

-Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч Н.Энхбаярын илтгэл-



“Мармара” сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Евразийн дээд хэмжээний чуулган энэ сарын 21, 22-ны өдөр Туркийн Истанбул хотод 27 дахь удаагаа боллоо. Энэ удаагийн дээд хэмжээний чуулганаар хүн төрөлхтний өмнө тулгамдаж байгаа асуудлууд буюу дайн ба энхийн асуудал, байгаль

Эрхэм хүндэт доктор Сүжэр ээ, Эрхэм хүндэт анд нэхэд өв, Ноёд, хатгалтай нар аа, Намайг Евразийн 27 дахь дээд хэмжээний чуулганд урин оролцуулж байгаад болон та бидний санаа сэтгэлийг зовоож буй асуудлуудын талаар санал бодлоо хуваалцах боломж олгосонд талархлаа дэвшүүлж байна.

## ХАВСРАЛТ 8.

### Бодит мэдээлэл: Эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангах нь

Ардчилсан нийгэмд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй нь маш чухал хувь нэмэр оруулах бөгөөд олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэн тэдний мэдэх эрхийг хангаж улмаар зөв шийдвэр гаргахад тусалдаг. Мөн тэнцвэртэй, ёс зүйтэй мэдээллийг олон нийтэд хүргэсний үндсэн дээр иргэдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн оролцоог идэвхжүүлэх, бэхжүүлэх боломжтой. Иймд, нийгмийн олон янзын төлөөллийн тулгамдсан асуудал, ашиг сонирхол, үзэл бодол, байр суурийг иргэдэд хүргэх нь ялангуяа сонгуулийн үеэр асар чухал байх юм.

### Эх сурвалжийн хүйсийн тэгш бус байдал

1978 онд профессор Жеорж Гербнер хүйс, арьс өнгө зэргээс хамаарч нийгмийн зарим бүлгийн төлөөллийг хэвлэл мэдээллээр хавьгүй бага гаргадгийг, тэр нь эргээд тэгш бус байдлыг өөгшүүлдгийг тодорхойлсон “symbolic annihilation” буюу “төлөөллийн огоорол” томъёоллыг гаргасныг өмнө нь дурдсан. Үүнийг социологич Гэе Тачман дэлгэрүүлэн судалж, хэвлэл мэдээлэл эмэгтэйчүүдийг цөөн гаргахаас гадна хэвшмэл ойлголтыг дэвэргэсэн байдлаар, ихэвчлэн хохирогч эсвэл хэрэглэгчийн дүрээр, мөн жендэрийн уламжлалт үүрэг буюу гэрийн эзэгтэй, ээж, эсвэл эмэгтэйчүүдийн түлхүү хийдэг ажлын дүрээр гаргадгийг онцолсон байдаг. Мөн эмэгтэйчүүдийг биеэ даасан, хүчирхэг байдлаар бус, харин эрэгтэйчүүдтэй хамааруулж дүрслэх нь элбэг байдгийг судалгаагаар нотолжээ.

Үүнээс хойш хагас зуун жил өнгөрсөн

30%



Шинжлэх ухаан, эрүүл мэнд

32%



Нийгэм, эрх зүй

24%



Гэмт хэрэг, хүчирхийлэл

25%



Олны танил хүмүүс, урлаг, спорт

24%



Эдийн засаг

20%



Улс төр, засгийн газар

ч байдал нэг их өөрчлөгдсөнгүй. Таван жил тутам нэг өдрийг сонгож мэдээний мониторинг хийдэг Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн төслөөс эмэгтэйчүүдийн дуу хоолойг гаргах тал дээр хэвлэл мэдээллийн салбар хойш суусаар байгааг анхааруулдаг. 1995 онд энэхүү мониторингийг анх хийхэд мэдээний субъект буюу мэдээгээр гарсан хүмүүсийн ердөө 17 хувь нь л эмэгтэйчүүд байж. Үүнээс 25 жил өнгөрөхөд энэ үзүүлэлт 25 хувьд л хүрчээ. Хэрвээ энэ чигээр ахиц удаан байвал жендэрийн тэгш байдлыг мэдээний агуулгад харахын тулд бид дор хаяж 67 жил хүлээх хэрэгтэй болно.

Мэдээ мэдээллийг сэдвээр нь ангилж үзвэл шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгэм, эрх зүйн сэдвээр эх сурвалжуудын 30 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол улс төр, засгийн газартай холбоотой сэдвээр ердөө 20 хувьтай байгааг графикаас харна уу.

График 2. Нийт эх сурвалжид эзлэх эмэгтэйчүүдийн хувь (сэдэвчилсэн байдлаар) Эх сурвалж: Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн төслийн 2020 оны тайлан

Мөн эмэгтэйчүүдийг элбэг гаргадаг шинжлэх ухаан, эрүүл мэндийн сэдэв нь мэдээний нийт агуулгын ердөө найман хувийг эзэлж байна. Гэтэл эмэгтэйчүүдийг цөөн эш татдаг улс төр, засгийн газрын талаарх мэдээлэл мэдээний хамгийн их буюу 25 хувийг эзэлдэг аж.

Мэдээний агуулга дахь эх сурвалжуудын 25 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг задалж үзвэл гэрийн ажил болон эцэг эхийн үүргээр гарсан мэдээний эх сурвалжуудын 68 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа бол засгийн газар, улстөрч, сайд, хэвлэлийн төлөөлөгчийн үүргээр гарсан эх сурвалжуудын ердөө 18 хувийг эзэлж байгааг өмнө нь дурдсан .

Тэгвэл сонгуулийн үеэр хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг гаргахдаа хойрго ханддагийг, гаргалаа ч хэвшмэл ойлголтын дагуу дүрсэлдгийг олон улсад сүүлийн 30 гаруй жил хангалттай олон судалгаагаар баримтжуулсан байдаг. Монгол Улсад ч сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэл болон нийгмийн мэдээллийн сүлжээний мониторинг хийхдээ жендэрийн тэгш бус байдал байгааг илчилсэн цөөнгүй баримтжуулалт хийжээ. Үүнд:

# 14%

2016 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 25 хувь нь эмэгтэйчүүд байсан бол сонгуулийн сурталчилгааны үеийн нийт контентын 14 хувь нь л эмэгтэй нэр дэвшигчдийн талаар дурджээ .

# 19%

“Глоб Интернэшнл Төв” ТББ-аас 2020 оны сонгуулийн үеэр хийсэн телевизийн мониторингийн судалгааны үр дүнгээс үзэхэд МҮОНТ-ээр гаргасан нэр дэвшигчтэй шууд холбоотой мэдээллийн 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэйчүүдэд оногдсон байв. Арилжааны телевизүүд үүнээс ч муу үзүүлэлттэй байсан бөгөөд нэг нь эрэгтэй нэр дэвшигчдэд 90 хувь, эмэгтэй нэр дэвшигчдэд 10 хувийн цаг гаргасан аж.

# 32%

Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн судалгаагаар Фэйсбүүк дэх сонгуультай холбоотой мэдээний агуулгад эрэгтэй нэр дэвшигчдийн тухай мэдээлэл илт давамгайлж байсныг илчилжээ. 2020 оны ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн 32 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан ч аль нэг эмэгтэй улстөрч, нэр дэвшигчийг дурдсан агуулга сонгуультай холбоотой агуулгын дөнгөж гурван хувийг, харин эрэгтэй нэр дэвшигчдийг дурдсан мэдээлэл 57 хувийг эзэлж байв. Сонгуулийн сурталчилгааны үеийн мэдээллийн үлдсэн 40 хувь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиныг нь багтаасан хэсэг, бүлгийн тухай байжээ .

# 9.5%

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд хийсэн судалгаагаар өдөр тутмын сонины улс төрийн мэдээллийн эх сурвалжийн 14 хувь, мэдээллийн сайтуудын эх сурвалжийн 9.5 хувь л эмэгтэйчүүд байна. Мөн өдөр тутмын сонины хувьд Топ 20 эх сурвалжийн давтамж нийт аман эх сурвалжийн 52 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, өдөр тутмын сонины хоёр аман эх сурвалжийн нэг нь нэр бүхий 20 улстөрч байгаагийн хоёр нь л эмэгтэй байв. Тэгвэл мэдээллийн сайтуудын хувьд Топ 30 эх сурвалжийн давтамж нийт эх сурвалжийн 74 хувийг эзэлж байгаагийн дунд гурван эмэгтэй улстөрч багтжээ.


Энэ бүхнийг дүгнэж харвал, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаа ч хэвлэл мэдээллээр тэдний тэн хагасынх нь дуу хоолойг ойшоохгүй, орхигдуулж байгаа юм. Үүнд бид өөрчлөлт хийхгүй бол 2024 оны сонгуулийн үеэр эмэгтэй нэр дэвшигчдийн тоо нэмэгдсэн ч хэвлэл мэдээллээр тэдний улс төрийн байр суурь, үзэл бодлыг хүргэхгүй, улмаар сонгогчид тэднийг таньж мэдэж, мэдээлэлтэй сонголт хийх боломж бүрдэхгүй билээ.



## Эх сурвалжийн олон талт байдлын хэлбийлт

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд хийсэн мониторингийн судалгаанаас үзэхэд өдөр тутмын сонин, сайтуудын улс төрийн мэдээллийн нийт эх сурвалжийн 97/99 хувийг дан ганц сонирхлын бүлгийн эх сурвалж буюу нөлөө бүхий улстөрчид, албан тушаалтнууд эзэлж байв. Үр дагавар хүртэгсэд, мэргэжлийн бүлгийн эх сурвалж үзэгдэх төдий л байгааг энэ судалгаа

харуулсан. Иймд, улс төрийн мэдээллийг тэнцвэртэй, олон талын байр суурийг илэрхийлсэн байлгахын тулд улстөрч эмэгтэйчүүдийг элбэг эш татахаас гадна үр дагавар хүртэгсэд болон мэргэжлийн бүлгийн эх сурвалжаар эмэгтэйчүүдийг оролцуулахад анхаарах шаардлагатай байгаа юм.



## ХАВСРАЛТ 9.

### Мэдрэмжтэй өнцөг: Жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь

Жендэрийн хэвшмэл ойлголт нь аль нэг хүйсийн хүмүүс, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан, ерөнхий ойлголт юм. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаар харилцан адилгүй хэм хэмжээг нийгэмд тогтоон хүлээлт үүсгэж, тодорхой дүрийг хувь хүмүүст тулгаж байдгаараа хувь хүний хөгжил дэвшил, өөрийгөө илэрхийлэхэд саад тоггор болдог. Улмаар жендэрийн хэвшмэл ойлголт нь шударга бус хандлага, аливаа шударга бус байдлыг зөвтгөх шалтгаан болж байдаг. Тиймээс ч ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголтоос зайлсхийх нь сэтгүүлчдийн мэргэжлийн, ёс зүйн чухал стандарт болсон билээ.

Жендэр, хэвлэл мэдээллийн харилцаа холбоо талаас фрэймингийн онолоор судалсан олон арван жилийн ажлын үр дүн хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг хэвшмэл ойлголтын дагуу дүрсэлдгийг баталсан байдаг. Эмэгтэй хүнийг эхний ээлжинд хүйсээр нь, дараа нь биеэ авч явах байдлаар нь, зөвхөн үүний дараа л (тэгээд хэрвээ энэ нь сэтгүүл зүйн бүтээлд зайлшгүй чухал байвал) тэднийг мэргэжил, албан тушаалынх нь дагуу загварчлан гаргадаг хэмээн “Жендэр, улс төр ба мэдээ: Гурван талын тоглоом” номын зохиогч Карен Росс тайлбарлажээ. Олон улсад болон Монголд хийсэн судалгааны ололтууд дээр үндэслэн эмэгтэй улстөрчдийг хэвшмэл ойлголтын дагуу харуулдаг нийтлэг зургаан алдаа болон тэдгээрээс зайлсхийх арга замыг хуваалцъя.

### Эмэгтэй нэр дэвшигчийн талаар мэдээлэхдээ хэвшмэл ойлголтоос зайлсхийх ЗУРГААН АЛХАМ

**1.** Хэвлэл мэдээлэл эмэгтэй улстөрчдийн хувийн амьдралын талаар сурвалжлан гаргах нь нэмэгдсэн гэж Карен Росс тэмдэглэжээ. Ийм жишээ Монголд ч гардаг. Тухайлбал, нэг мэдээллийн сайт сошиал хуудсаараа БНН-ын дарга Б.Жаргалсайхан УИХ-ын нэгэн эмэгтэй гишүүнийг дөрвөн өөр хүний дөрвөн хүүхэдтэй гэж хэлснийг ямар ч шүүлтүүргүй, нягтлан шалгахгүйгээр олон нийтэд хүргэсэн. Энэ промо нь хүйсээр ялгаварлан гадуурхсан, эмэгтэйчүүдийг дорд үзсэн талаарх иргэний гомдол Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирсэн бөгөөд редакц ёс зүйн ноцтой алдаа гаргасныг тогтоож байв. Редакц алдаагаа ухамсарлаж, Фэйсбүүк хуудаснаасаа сурталчилгааг

устгасан боловч хэдийнэ дуулиан шуугиан дэгдээж амжсан.

Хувийн нууцад хүндэтгэлтэй хандах, бусдыг гүтгэхгүй байх тухай Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тусгасан байдаг. Иймд, ёс зүйтэй, мэргэжлийн байх үүргээ биелүүлэхэд л ийм хэвшмэл хандлагаас зайлсхийх боломжтой.

**2.** Эмэгтэй улстөрчдөд элдвээр нэр хоч өгөх байдлаар дорд үзэх стратегийг хэвлэл мэдээлэл түгээмэл ашигладгийг мөн Карен Росс онцолжээ. Их Британийн 1997 оны сонгуулийн үеэр эмэгтэй парламентын гишүүдийн тоо хоёр дахин нэмэгдэхэд тэднийг “Blair’s

Babes” буюу Ерөнхий сайд Тони Блэйрийн “хонгорууд” хэмээн хэвлэл мэдээллийнхэн гаргаж ирсэн. Монголд ч “Бенз”, “Боов”, “Кэндикраш”, “Хатан ижий”, “Төмс” гэх мэтээр нэр хоч өгсөн жишээг бид олноор нь мэднэ. Үүнийг сургалтын үеэр ярихад оролцогчид эрэгтэйчүүдэд ч бас нэр хоч өгдгийг сануулах нь бий. Хэдий тийм ч эмэгтэй болон эрэгтэй улстөрчдийн нэр хочийг хэлүүлж, самбар дээр тэмдэглэхэд эмэгтэйчүүдийнх илт олон болдог юм. Үүний зэрэгцээ, эмэгтэйчүүдэд өгсөн нэр хоч доромжилсон, тохуурхсан агуулгатай байх нь элбэг. Бусдыг доромжлохгүй байхыг мөн л ёс зүйн зарчимд тусгасан байдаг бөгөөд мэргэжлийн сэтгүүлч хэзээ ч ийм алдаа гаргах ёсгүйг сайтар анхаараарай.

**3.** Эмэгтэй нэр дэвшигчид, улстөрчдийн гэр бүлийн амьдралыг тодотгож, тэднийг улс төрийн ажлаа ээж, эмээгийн үүрэг хариуцлагатайгаа хавсран хийж чадах эсэхийг асуудаг нь түгээмэл байдгийг профессор Виржиния Гарсия Боудоу онцолжээ. Тухайлбал, АНУ-ын 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших сунгаанд өрсөлдөж байсан Хиллари Клинтоны охин жирэмсэн болсон мэдээллийг хэвлэл мэдээлэл онцолж, эмээгийн үүрэг хариуцлагаа яах талаар сониучирхаж байсан удаатай. Гэтэл бид олон хүүхэдтэй аав, өвөө нараас ийм асуулт асуудаггүй. Монголд ч мөн эмэгтэй улстөрчдийг сайн эхнэр, ээж мөн эсэхийг чухалчилж авч үздэг. Иймд, улстөрч эмэгтэйн талаар нийтлэл/нэвтрүүлэг бэлтгэхдээ хэдэн хүүхэдтэй, хэр сайн ээж вэ гэдгийг зайлшгүй шаардлагатай биш л бол оруулах хэрэггүй.

**4.** Хэвлэл мэдээллээр эмэгтэй улстөрчдийг дүрсэлдэг дараагийн нэг загвар нь тэднийг нөлөө бүхий эрчүүдийн дагуул дүрээр гаргах юм. Улстөрч Ц.Оюунгэрэл “Ц.Элбэгдоржийн хүн”, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд асан Б.Болор-Эрдэнэ “Ерөнхий сайдын хүн” гэж

бичсэн олон жишээ хэвлэл мэдээллийн агуулгад мониторинг хийх үед илэрч байв. Мөн А.Ариунзаяа, Ч.Номин, С.Одонтуяа нарыг олны танил аав, өвөөгөөр нь овоглодог жишээ ч бий. Өндөр албан тушаалтай эмэгтэй хүнийг өөрийн чадлаар гарч ирээгүй, ямар нэг нам хүчин, нөлөө бүхий хүний туслалцаатайгаар тодорсон гэх хандлага байдгийг “Глоб Интернэшнл Төв” ТББ-аас эмэгтэй улстөрчдийн талаар хийсэн Хэвлэл мэдээллийн мониторингийн тайланд дүгнэжээ. Иймд, эмэгтэй улстөрчийг нөлөө бүхий эрэгтэй хүнд хамааруулж гаргахаас зайлсхийгээрэй.

**5.** Нас, биеийн галбир, төрх, хувцаслалт, нүүр будалт, биеэ авч явах байдал зэрэг эрэгтэй улстөрчдийн талаар дурддаггүй зүйлсийг эмэгтэй улстөрчдийг дүрслэхдээ тоочдог. Эрэгтэй хүнийг боловсрол, ажил мэргэжлийн туршлага, алдаа оноогоор нь дүрсэлдэг хэрнээ эмэгтэй хүнийг царай зүс, бие галбир, өмссөн зүүснээр нь сонжих хандлага хүйсээр ялгаварлаж байгаа хэрэг гэдгийг сайтар ойлгоорой.

**6.** Хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой ноцтой асуудал гарах бүрд УИХ-ын эмэгтэй гишүүд ажлаа хийхгүй байна гэж шүүмжлэх тохиолдол Монголын хэвлэл мэдээлэлд мөн элбэг ажиглагддаг. Энэ нь хүйсээр илт ялгаварласан хэрэг болохыг сайтар ойлгоорой. Нэгдүгээрт, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлд яагаад эрэгтэй гишүүд оролцох ёсгүй гэж? Хоёрдугаарт, УИХ-ын эмэгтэй гишүүдийн оролцоотойгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг баталсан бөгөөд хэрэгжилтийг зохих байгууллагуудаас шаардах нь зүйтэй юм. Иймд, УИХ-ын эмэгтэй гишүүдийг шүүмжлээд өнгөрөх бус, системийн алдааг эрж олж, зохих байгууллагууд, албан тушаалтнуудаас хариуцлага нэхэх нь мэргэжлийн сэтгүүлчдийн хийх хавьгүй үр дүнтэй ажил билээ.

# ХАВСРАЛТ 10.

## Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

1. Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

1.1 Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.

1.2 Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ.

1.3 Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, эшлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.

1.4 Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй.

1.5 Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана.

1.6 Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурдана.

1.7 Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцын агуулгаас ялгаж тэмдэглэнэ.

1.8 Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно.

1.9 Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.

2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.

2.1 Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэргэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно.

2.2 Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.

4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.

5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.

2.3 Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түрүүнд оюун санааны болон бие махбодын хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна.

2.4 Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.

3.1 Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ.

3.2 Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.

4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ.

4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.

4.3 Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дуурайх, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй.

4.4 Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана.

4.5 Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй.

4.6 Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.

5.1 Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана.

6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.

6.1 Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана.

6.2 Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно.

6.3 Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй.

6.4 Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй.

6.5 Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй.

6.6 Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ.

6.7 Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ.

6.8 Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.

7. Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.

8. Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.

9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.

10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.

9.1 Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана.

## Сонгогчийн боловсрол ба ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ

Хэвлэл мэдээллээр эмэгтэй улстөрч, нэр дэвшигчдийг хэрхэн хэвшмэл ойлголтын дагуу дүрсэлдгийг энэхүү удирдамжид дэлгэрэнгүй авч үзсэн. Үүнийг сэтгүүлчид ихэнхдээ санаатайгаар бус, жендэрийн мэдлэг султайгаасаа болж гаргасан байдаг. “Мэдрэмжтэй мэдээлье” сургалтад суусан, нэгдлээс гаргасан зөвлөмж, нөөц хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжтой болсон гишүүд маань хэвшмэл ойлголтоос зайлсхийх мэдлэг, чадварыг маш сайн эзэмшдэгийг дуулгахад таатай байна. Иймд, уншигч, үзэгч, сонсогчдоо ч энэ боломжийг бүрдүүлж өгөх нь чухал билээ.

Олон нийтийн дунд бат бэх оршсоор байгаа жендэрийн хэвшмэл үзэл эмэгтэй улстөрчдөд саад тотгор болдгийг олон судалгаа харуулдаг. Тухайлбал, улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй ажиллаж буй эмэгтэйчүүдийн үнэмлэхүй олонх нь сонгогчдын жендэрийн мэдлэг сул байгааг онцолжээ. Харин одоо сүүлд гарсан судалгаануудын ололтуудыг багцлан хүргэе.

*“Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл” судалгааны тайлангаас...*

Хөрөнгө санхүү, боловсрол, гэр бүлийн байдал, олон нийтэд танигдсан байдал, туршлага, танилын сүлжээ, тууштай байдал, ур чадвар гэсэн найман хүчин зүйл улстөрч залуучууд болон эмэгтэйчүүдийн амжилтад голлон нөлөөлж байна. Харин эмэгтэй улстөрчдийн гэр бүлийн байдал нь тухайн хүний мэдлэг боловсрол, ур чадвараас ч чухал шалгуур үзүүлэлт болдог ажээ.

Эмэгтэй улстөрчдийн хувьд ганц бие байх, өрх толгойлсон ээж байх, гадаад нөхөртэй байх зэрэг нь улстөрийн карьерын хувьд эмзэг тал болдог талаар судалгаанд оролцсон олон эмэгтэй хэлсэн байна. Мөн эмэгтэйчүүд үр хүүхдээ төрүүлж, өсгөж, гэр бүлийн гишүүддээ анхаарал тавьж байх ёстой гэсэн хэвшмэл ойлголт эмэгтэй хүн улс төр хийхэд олон нийтийн зүгээс таагүй хандах шалтгаан болж байгааг судалгаанд онцолжээ.

*“SheVotes Mongolia: Эмэгтэйчүүд,*

*залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүд” судалгааны тайлангаас...*

Улс төрд оролцдог эмэгтэйчүүдийг ихэвчлэн “амбицтай” гэж сөргөөр, шударга бусаар шүүмжилдэг, элдвээр гүтгэж, сөрөг сэтгэгдэл бичдэг, мөн хэвлэл мэдээлэлд голцуу сөрөг талаас нь харуулах, эсвэл хувь хүний ур чадвар, туршлагаас илүүтэй хувийн амьдрал, гадаад үзэмжээр нь дүгнэх хандлага түгээмэл байна.

Нийгэмд оршдог жендэрийн хэм хэмжээний дагуу эмэгтэйчүүд улс төр, олон нийтийн ажил үйлсээс илүү гэр ахуйн үүргээ чухалчлахыг шаарддаг. Энэ нь эмэгтэйчүүд илүү захиргааны, бичиг цаасны ажил хариуцаад, харин эрэгтэйчүүд удирдах түвшний албан тушаал хашдаг гэсэн түгээмэл дүр зурагтай холбоотой байж мэдэхийг мөн дурджээ.

*“Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгааны тайлангаас...*

- Нийт 1006 хүний дунд хийсэн энэхүү судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна гэж хариулжээ. Гэвч...
- Удирдах албан тушаал эрхэлж чадах тухайд “эмэгтэй” хүнд үл итгэх хандлага судалгаанд оролцогчдын 20 орчим хувьд ажиглагдаж байна.
- Судалгаанд оролцогч арван хүн тутмын долоо нь эрэгтэй хүнд саналаа өгсөн бөгөөд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага зэрэг илүүгээр эмэгтэйчүүдийг дэмжжээ.
- УИХ-ын 76 гишүүний 17 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгааг судалгаанд оролцогчдын 42 хувь нь хангалтгүй, 39.6 хувь нь боломжийн, 25.9 хувь нь хангалттай гэж үзжээ. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 48.8 хувь нь “хангалтгүй” гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 65.5 хувь нь “боломжийн, хангалттай” гэж үзсэн

байна.

- Чанарын судалгааны баримтаар эрэгтэй хүнийг эцгийн эрхт ёсны дүрээр буюу гэр бүлээ тэжээх үүрэгтэй, удирдах ажилд илүү тохиромжтой, чадвартай харин эмэгтэй хүнийг хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлэх, гэрийн бүх асуудлыг зохицуулдаг байх дүрээр илүүд үзэх хандлага бүх насны эрэгтэй, эмэгтэйчүүдэд зонхилон илэрчээ.
- Эрэгтэйчүүдийг алсын хараатай, шийдэмгий, зоригтой, шулуун, шударга байж чадна хэмээн дэмжиж байгаагаас гадна захирах, засаглах эрх мэдлийг эрэгтэй хүнд оноодог хэвшмэл үзлээр хандаж байна. Харин эмэгтэй хүний нягт нямбай чанартай холбож, амьдралын олон асуудлыг эмэгтэй хүн л харж шийдвэрлэнэ гэсэн хүлээлт, хийж чадна, чадаж байна гэсэн өнцгөөр тайлбарлаж байна.
- Олон нийтийн сонгосон хариултаар, улс төрийн манлайлагчаас шийдэмгий чанарыг 83.4 хувь хүссэн нь хамгийн өндөр давтамжтайгаар илэрсэн бол үүний дараагаар 66.8 хувь нь зоригтой байх, 59.3 хувь нь бусдыг ойлгодог байхыг чухалчлах хандлагатай байна. Эндээс дүгнэхэд, олон нийт ихэвчлэн эрэгтэй улстөрчдөд хамаатуулдаг чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээж байна.

- Олон нийт эмэгтэй улстөрчөөс нэг талаас эрэгтэй улстөрч шиг байхыг хүлээхийн зэрэгцээ эмэгтэйлэг байхыг шаарддаг аж. Энэ нь эмэгтэй улстөрчдөд давхар шаардлага тавьж байгааг харуулна.

Энэ бүх судалгаа сонгогчдын жендэрийн мэдлэг, мэдрэмж сул байгааг харуулах бөгөөд ийм нөхцөлд эмэгтэй нэр дэвшигчдийн тоо нэмэгдлээ ч эрэгтэйчүүдтэй шударгаар, нэг гараанаас өрсөлдөх боломжгүй билээ. Иймд, сонгогчдын боловсролыг дээшлүүлж, хэвшмэл ойлголтыг халах тал дээр хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг туйлын чухал байх юм.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй холбоотой нийтлэг хүлээлтийг эвдэхүйц сэтгүүл зүйн бүтээлийг хэвшмэл ойлголтыг халсан гэж тодорхойлдог. Хэвшмэл ойлголтыг халсан сэтгүүл зүйн бүтээл нь аливаа асуудлыг харах шинэ өнцөг, байр суурь, бодолцох шинэ арга замыг олоход тусалдаг гэж Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн аргачлалын зааварт тайлбарлажээ. Мониторингийн үр дүнгээс харахад нийт мэдээний ердөө дөрвөн хувь нь л жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад чиглэсэн байна. “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн сэтгүүлчид жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад чиглэсэн маш олон бүтээл хийж олон нийтэд хүргэснээр уншигч, үзэгч, сонсогчдоосоо таатай сэтгэгдэл авч эхэлсэн туршлага бий.



## ЦОНХ: “ЗУУНЫ МЭДЭЭ” СОНИНЫ “ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТОО ӨӨРЧИЛЬЕ” БУЛАН

Зууны мэдээ” сонины хамт олон “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрт хамрагдах үеэрээ “Хэвшмэл ойлголтоо өөрчилъе” булангаа нээсэн юм. Эрэгтэйчүүд давамгайлсан улс төр, уул уурхай, мэдээллийн технологи зэрэг салбарт ажилладаг эмэгтэйчүүд, мөн цэцэрлэг, сургууль, гоо сайхны салбарт ажилладаг эрэгтэйчүүдийг онцлон гаргахын зэрэгцээ олон нийтийн хэвшмэл үзлийг халахад чиглэсэн олон сонирхолтой сэдэв, өнцгөөр бүтээл гаргасан. Ингэснээр “Зууны мэдээ” сонины редакц руу уншигчид нь залгаж, энэхүү

буландаа урьж оролцуулж болох хүмүүсийг санал болгох нь нэмэгдсэн байна. Сонины сэтгүүлчдийн хувьд ч энэ буландаа зориулж бүтээл хийх нь илүү сонирхолтой санагддаг болсныг онцлон ярьж байлаа.

Улмаар, “Хэвшмэл ойлголтоо өөрчилъе” буландаа 2022 оны долоодугаар сараас эхлэн нэг жилийн хугацаанд гаргасан бүтээлүүдээ нэгтгэн цахим ном болгож уншигчдадаа хүргэснийг дараах линкээр авч унших боломжтой.

Линк: <https://www.calameo.com/read/0074109542c313d414e2f>



## “Мэдрэмжтэй Мэдээлье” нэгдлийн танилцуулга

### ЗОРИЛГО

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл нь жендэрийн мэдрэмжтэй, ёс зүйтэй сэтгүүлч, редакторуудын мэдлэг, чадвараа сайжруулах, харилцан туршлага солилцох, салбартаа манлайлах, уншигч, үзэгчдийнхээ итгэлийг хүлээх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой. Нэгдлээс шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлын асуудлыг даацтай мэдээлэх, нийгэм дэх хэвшмэл буруу ойлголтыг халахад чиглэсэн чанартай, ёс зүйтэй бүтээлүүд гаргах гишүүдийнхээ санаачилгыг урамшуулан дэмжиж ажиллана. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд:

- ▶ Нэгдэлдээ шинэ гишүүн хүлээж авахдаа үргэлж нээлттэй, баяртай байна;
- ▶ Бие биеийнхээ, мөн олон улсын сайн туршлагаас байнга суралцаж, хөгжиж байна;
- ▶ Жендэрийн мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачдыг үйл ажиллагаандаа урин оролцуулж, мэргэжлийн байр суурь, дата судалгааг өндөрт тавин судалж байна;
- ▶ Улстөрч эмэгтэйчүүдтэй шударга, мэргэжлийн байр сууринаас харьцаж байна.

### БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

**Олон ургалч байдал:** Нийгмийн янз бүрийн төлөөллийн дуу хоолойг уншигч, үзэгч, сонсогчдоо хүргэх нь олон ургалч үзлийг түгээх чөлөөт хэвлэлийн үүрэг гэдэгт бид итгэдэг. Эмэгтэйчүүдийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд төдийгүй сэтгүүл зүйн агуулгад цөөн байгаа учраас бид мэдээ, сурвалжилга, ярилцлага хийхдээ эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахыг хичээнэ;

#### **Мэргэжлийн ур чадвар, ёс зүй:**

Хэнийг ч ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл буруу ойлголтын золиос болгохгүй байх нь сэтгүүлчийн мэргэжлийн, ёс зүйн үүрэг хариуцлага билээ. Тиймээс сэтгүүл зүйн бүтээлээ цоо шинэ, чухал өнцгөөс, жендэрийн мэдрэмжтэйгээр гаргахыг чармайн ажиллана.

#### **Тогтвортой хөгжил:**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтын хэрэгжилтийг хянах, олон нийтэд ойлгуулахад хэвлэл мэдээллийн

салбар чухал үүрэгтэй гэж бид үздэг. Иймд, жендэрийн тэгш бус байдал, хүний эрхийн асуудлыг гүнзгийрүүлэн судалж, баримтад тулгуурласан даацтай бүтээл хийнэ.

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийг Хэвлэл мэдээллийн зөвлөл болон Анлимитэд медиа группийн хамтарсан консорциумаас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА), НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байгаа “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд үүсгэн байгуулсан.

Эдүгээ “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл нь 300 гаруй гишүүнтэй бөгөөд өргөжин тэлсээр байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд “Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь” сургалтын хөтөлбөр боловсруулж, 500 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг хамруулсан сургалт, үйл ажиллагаанууд зохион байгуулаад байна. Нэгдлээс эх сурвалжийн дата сан бүрдүүлэх Хакатон хийж, улс төр, эдийн засаг, уул уурхай, хөдөө аж ахуй, технологийн чиглэлээр ярилцлага өгөх боломжтой 400 гаруй эмэгтэй эх сурвалжийн мэдээллийн сан бүрдүүлсэн. Үүнийг нэгдлийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудад өгч, ашиглуулж байгаа юм.

Мөн Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрийг 2022 оны зургаадугаар сараас хэрэгжүүлсэн бөгөөд CoGo.mn мэдээллийн сайт, “Зууны мэдээ” сонин, Архангай медиа групп, Монголын үндэсний олон нийтийн радиогийн хамт олныг эхний ээлжинд амжилттай хамруулаад байна. Хоёр сарын хугацаатай энэхүү хөтөлбөр нь редакцын удирдлагад бодлогын болон менежментийн зөвлөгөө өгч, хэвлэл мэдээллийн салбарт ялгарч, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, BBC-ийн 50:50 төсөл болон олон улсын бусад амжилттай туршлагаас судлах, суралцах, хамтран ажиллах боломжийг нээж өгөх зорилготой.

Энэжилээс “Мэдрэмжтэй мэдээлье” виртуал редакц ажиллуулж эхэлсэн бөгөөд сар бүр жендэрийн эрх тэгш байдлын сэдвээр 15 бүтээл гаргах юм.

Та “Мэдрэмжтэй мэдээлье” Фэйсбүүк пэйж болон группээс нэгдлийн үйл ажиллагаа, шинэ боломжуудын талаарх мэдээллийг аварай.

## Жендэрийн нэр томъёоны товч тайлбар

**ХҮЙС** гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биологийн болон генетикийн хувьд ялгагдах шинжүүдийг хамаарсан ойлголт юм. Эдгээр шинж нь /мэс ажилбар болон дааврын эмчилгээнээс бусад тохиолдолд/ хувирч өөрчлөгддөггүй гэдгээрээ нийтлэг байдаг.

**ЖЕНДЭР** гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд нийгмээс бий болгосон хэм хэмжээ, үүрэг, дүр төрх, нийгмийн хандлагын ялгааг хамаарах ойлголт юм. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд жендэр гэдэг нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ.

**ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ ҮНЭЛЭМЖ** гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст ийм байх ёстой гэж нийгмээс тогтоосон нийтлэг дүр төрх, стандарт юм. Үүнийг онолын хувьд жендэрийн хэвшмэл үзэл гэж тодорхойлсон байдаг.

**ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ҮЗЭЛ** гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг хэлэх бөгөөд өөрөөр хэлбэл аль нэг хүйсийн хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан, ерөнхий ойлголт юм. Энэ нь аль нэг хүйсийн хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаар харилцан адилгүй хэм хэмжээг нийгэмд тогтоон хүлээлт үүсгэж, тодорхой дүрийг хувь хүмүүст тулгаж байдгаараа хувь хүний хөгжил дэвшил, өөрийгөө илэрхийлэхэд саад тотгор болдог. Улмаар жендэрийн хэвшмэл ойлголт нь шударга бус хандлага, аливаа шударга бус байдлыг зөвтгөх шалтгаан болж байдаг.

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ** гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.

**ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ НЬ** тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц, урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх ба хүртэх боломжтой байх тухай ойлголт. Гэхдээ орчин цагт жендэрийн тэгш байдлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай хандах бус, харин нөхцөл байдал, боломжийг нь адил тэгш болгоход анхаарах явдал гэж ойлгох болсон. Өөрөөр хэлбэл, энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс биологийн хувьд өөр өөрийн онцлогтой ч тэдний эдлэх боломж бололцоо нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх тухай ойлголт юм.

**ЖЕНДЭРИЙН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ** гэдэг нь аливаа үйл ажиллагаанд оролцож буй, эсхүл тодорхой үзүүлэлтэд хүрсэн охид хөвгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тооны харьцааг илэрхийлдэг. Жендэрийн тэнцвэр нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны амжилтыг хэмжих хамгийн энгийн үзүүлэлт болон ашиглагдах нь элбэг байдаг ч эмэгтэй эрэгтэй хүмүүсийн оролцооны чанар, агуулгыг харуулдаггүй. Бичиг үсэг тайлагдалт, сургуульд хамрагдалт зэрэг охид хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн боловсрол эзэмшилтэд гарч буй амжилтыг харьцуулан хэмжих зорилгоор, НҮБ-ын БСШУ-ны байгууллагаас Жендэрийн тэнцвэрт байдлын хэмжүүр (GPI)-ийг ашиглах болсон байна.

**ЖЕНДЭРИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ** гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар

ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

**ЖЕНДЭРИЙН ШУУД ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ** гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг хэлнэ.

**ЖЕНДЭРИЙН ШУУД БУС ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ** гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг хэлнэ.

**ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ / GENDER SENSITIVE APPROACH/** гэдэг нь Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, мөн хөгжлийн үйл явцад оролцох болох үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох, хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадварыг хэлнэ.

**ЖЕНДЭРИЙН ХАРИУЦЛАГАТАЙ / GENDER RESPONSIVE APPROACH/** гэдэг нь Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, мөн хөгжлийн үйл явцад оролцох болох үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг арилгахад хариуцлага хүлээн, устгахад чиглэсэн хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадварыг хэлнэ. Жендэрийн харилцаа гэдэг нь Эмэгтэй, эрэгтэй хүмүүс эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд ялгаатай үүрэгтэй байдаг. Тэрхүү үүргээ гүйцэтгэхийн тулд тэдэнд ялгаатай нөөц /эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын/, боломж хэрэгтэй. Иймд жендэрийн харилцаа нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондох нийгмийн ялгаатай байдал тухайлбал эрх мэдэл, байр суурь, боломжийн харилцан адилгүй байдал, тэдгээрт нөлөөлдөг хүчин зүйлүүдийн тодорхойлолт юм.

**ШИЛЖИЛТИЙГ ДЭМЖИХ ЖЕНДЭРИЙН ХАНДЛАГА** /Gender transformative approach/ гэж тогтолцооны өөрчлөлт хийх замаар жендэрийн эрх тэгш байдалд хүрэх, хувьсган өөрчлөх хандлага.

**ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ** гэдэг нь бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм.

## ЭХ СУРВАЛЖ:

(n.d.). Portraying Politics, a toolkit on gender and television.

50:50 The Equality Project. (2023). Impact Report.

BBC. (n.d.). Diversity and Inclusion Strategy 2016-20.

Council of Europe. (2017). Media, Elections and Gender: Study on media coverage of elections with a specific focus on gender equality.

European Institute for Gender Equality. (2012-2014). European Institute for Gender Equality: <https://eige.europa.eu/gender-mainstreaming/good-practices/ireland/irish-current-affairs-programme-gives-women-equal-place>

Fourth World Conference on Women. (1995). The Beijing Declaration and the Platform for Action . Beijing.

Gaye Tuchman. (2016). The Symbolic Annihilation of Women by the Mass Media. Culture and Politics. Springer.

Gender, Media and Election Watch. <https://nwmigenderwatch.wordpress.com/>

GMMP. (2020). Who Makes the News.

ICFJ. (2019). The State of Technology in Global Newsrooms.

Internews, United for News. (n.d.). Reflect Reality.

IPU. (2023). Women in Politics. ([ipu.org](http://ipu.org)).

Inter-Parliamentary Union. (1994). Plan Of Action to Correct Present Imbalances In The Participation Of Men And Women In Political Life, <http://www.ipu.org/wmn-e/planactn.htm>

Kassova, L. (2020). The Missing Perspectives of Women in News. Bill & Melinda Gates Foundation.

Kassova, L. (2022). From Outrage to Opportunity: How to Include The Missing Perspectives of Women of All Colors in News Leadership and Coverage. Internews.

Ross, K., Jansen, M., & Bürger, T. (2020). Chapter 6. The media world versus the real world of women and political representation : Questioning differences and struggling for answers. In Comparing Gender and Media Equality Across the Globe : A Cross-National Study of the

Qualities, Causes, and Consequences of Gender Equality in and through the News Media (pp. 233–257). <https://doi.org/10.48335/9789188855329-6>

Ross K. (2017). Gender, Politics, News: A Game of Three Sides.

UN Women, IDEA. (2011). The Election Coverage from a Gender Perspective, a Media Monitoring Manual.

WACC/IFJ. (2012). Learning Resource Kit for Gender-Ethical Journalism and Media House Policy. Toronto.

Women in News. (2020). Amplifying women's voices A Gender Balance Guide For Media.

World Economic Forum. (2021). Global Gender Gap Report 2021.

Б.Дулмаа, М. (2020, III). Монгол эмэгтэйчүүд ойкосын хүрээнээс полисын тавцанд гарсан нь. Жендэр судлал, 70-79.

Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн. (2021). SheVotes Mongolia: Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүд.

Г.Гүнжидмаа. (2020). Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендэрийн мэдрэмжид хийсэн үнэлгээ зөвлөх үйлчилгээний тайлан . Улаанбаатар.

Д.Мөнхчимэг. (2021). Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй: Редакцуудад зориулсан удирдамж . Улаанбаатар.

Д.Мөнхчимэг, Ц.Чимэддондог (2018). “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг” контент анализын судалгаа. Фридрих-Эбертийн-Сан.

Жендэрийн үндэсний хороо. (2018). Жендэр ба бодлого төлөвлөлт.

Жендэрийн үндэсний хороо. (2018). Жендэр ба бодлого төлөвлөлт.

Женнифер Мадж, Ж. Ц. (2014). Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь: Сургагч багшид зориулсан гарын авлага.

Л.Бямбаханд (2020). Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч

хүчин зүйлс. Т. Б. зөвлөл-Д, Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа (хуудсд. 25-61). Улаанбаатар.

С.Түмэндэлгэр. (2022). Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл.

Үндэсний статистикийн хороо. (2022). Иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь эмэгтэйчүүд.

Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2020). Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг.

Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2021). Хэвлэл мэдээллийн мониторингийн суурь судалгааны үр дүн.

Хэвлэлийн Хүрээлэн. (2016). Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг.

Хэвлэлийн хүрээлэн. (2017). Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцийн бодлого, сэтгүүл зүйн практик.

Хэвлэлийн хүрээлэн. Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан.

ХЭҮК. (2022). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл: Бүлэг II. Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх.

Ц.Бүжидмаа. (2022). Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага.

Цогц хөгжлийн үндэсний төв. (2021). Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл судалгааны тайлан.

Э.Гэрэлт-Од, Д. (2020, III). Монгол Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл, сорилт. Жендэр судлал, 80-85.

Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь. (2023) Жендэрийн хариуцлагатай мэдээлэл, харилцаа: Зөвлөмж.

ЮНЕСКО, Глоб Интернэшнл Төв. (2014). Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт.

